



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН
ТУШААЛ

2026 оны 01 сарын 13 өдөр

Дугаар А/08

Улаанбаатар хот

┌ Албан тушаалын тодорхойлолт батлах тухай ┐

Монгол Улсын Засгийн газрын тухай 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4, 2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Зам, тээврийн яамны харьяа Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны даргын албан тушаалын тодорхойлолтыг хавсралт ёсоор баталсугай.

2.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны Б/16 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Б.ДЭЛГЭРСАЙХАН

142630311



АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Нэгжийн нэр:

Албан тушаалын нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Ажлын цаг:

Ажлын байрны албан ёсны байршил:

Хөдөлмөрийн нөхцөл:

Онцгой нөхцөл:

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Иргэний нисэхийн тухай Монгол Улсын хуулийн 9-р бүлэг, 41, 42, 43 дугаар зүйлийн заалтууд, Чикагогийн Конвенцийн Хавсралт 13-ын дагуу Монгол Улсын нутаг дэвсгэр дээр гарсан агаарын хөлгийн осол, зөрчлийг хөндлөнгийн нөлөө, дарамт шахалтаас ангид, хараат бусаар шинжлэн шалгаж, шалтгааныг тогтоох, осол зөрчил давтагдан гарахаас урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн зөвлөмж гаргах, тус албаны үйл ажиллагааг удирдан зохион байгуулахад оршино.

Албан тушаалын зорилт:

- Иргэний агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажлыг мэргэжлийн удирдлагаар хангах;
- Иргэний агаарын хөлгийн осол, зөрчлийн талаар мэдээлэл хүлээн авах, хадгалах тогтолцоог бүрдүүлэн, зохих мэдээллийг холбогдох байгууллагад цаг тухайд нь мэдэгдэх, мэдээллийн сан болон бусад эх үүсвэрт тулгуурлан аюулгүй ажиллагааны талаар дүгнэлт, судалгаа тогтмол хийж зөвлөмж гаргах,

3. Албаны дотоод үйл ажиллагааны холбогдох стандарт, дүрэм, журам, зааврыг боловсронгуй болгох, албаны үйл ажиллагааг удирдан зохион байгуулах			
Зорилт	1. Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	<p>1.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт гарсан иргэний агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажлыг бие даан шуурхай эхлүүлэх, аливаа этгээдээс хараат бусаар удирдан зохион байгуулах;</p> <p>1.2. Гадны улсын агаарын зай, нутаг дэвсгэрт гарсан, Монгол Улсад бүртгэлтэй болон хамааралтай агаарын хөлгийн осол, ноцтой зөрчлийг шинжлэн шалгах ажилд Монгол Улсыг төлөөлж, бие даан хамтран оролцох, оролцох этгээдийг томилох, шинжлэн шалгах үйл ажиллагаанд хяналт тавих;</p> <p>1.3. Осол, ноцтой зөрчлийг шинжлэн шалгах ажиллагаа явуулах эрхийг харьяалал бүхий улсын шинжлэн шалгах байгууллагуудад хэсэгчлэн болон бүхлээр нь шилжүүлэх;</p> <p>1.4. Шинжлэн шалгах ажиллагааны баримт материалуудад тулгуурлан дүн шинжилгээ хийх, шалтгааныг тогтоож осол, зөрчлийн талаар үнэн зөв дүгнэлт тайлан гаргах;</p> <p>1.5. Шинжлэн шалгасан эцсийн тайланг сонсох, дүгнэлт өгөх, хөндлөнгийн нөлөө, дарамт шахалтаас ангид байх зарчмыг баримтлан, хараат бусаар тайланг батлах;</p> <p>1.6. Осол, зөрчлийн тайланд тулгуурлан Аюулгүй ажиллагааны зөвлөмж гарган, тэдгээрийн биелэлтэнд хяналт тавих;</p> <p>1.7. Шинжлэн шалгах ажиллагааны арга барил, технологи үйл ажиллагааг сайжруулж, шинжлэн шалгагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх, хадгалах сургалтыг батлагдсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулах;</p> <p>1.8. Шинжлэн шалгагч нарт эрх олгох;</p>	<p>Агаарын хөлгийн осол, ноцтой зөрчлийн үндсэн шалтгааныг тогтоож, шинжлэн шалгах ажиллагааг Иргэний нисэхийн тухай хууль, Чикагогийн Конвенцийн Хавсралт 13-ын шаардлагын дагуу явуулж, үнэн зөв дүгнэлт гарган энэхүү нөхцөл давтагдахаас урьдчилан сэргийлэх зорилгоор аюулгүй ажиллагааны зөвлөмж гарган, мэдээллэсэн байна.</p>	<p>Г, Х, Ш</p> <p>Х</p> <p>Х, Ш</p> <p>Г</p> <p>Г</p> <p>Х</p> <p>Г</p> <p>Ш</p>
2 дугаар зорилтын хүрээнд	<p>2.1. Иргэний агаарын хөлгийн осол, зөрчлийн талаар 24 цагийн турш мэдээлэл авах ажлыг тасралтгүй зохион байгуулах;</p> <p>2.2. Осол, зөрчлийн тухай мэдээллийг зөв ангилан бүртгэж, уг мэдээллийг салбарын Сайд болон холбогдох байгууллагад цаг тухайд нь мэдэгдэх;</p> <p>2.3. Агаарын хөлгийн осол, ноцтой зөрчлийн талаар Олон улсын иргэний нисэхийн байгууллага, холбогдох гадаад</p>	<p>Иргэний агаарын хөлгийн осол, зөрчлийн талаар мэдээлэл бүрийг системд бүртгэн, Монгол Улсын нутаг дэвсгэрт болсон осол, ноцтой зөрчилд шинжлэн шалгах ажиллагааг хийж, бусад улсын</p>	<p>Г, Х, Ш</p> <p>Г</p> <p>Г, Т</p>



	<p>улсын эрх бүхий байгууллагад тогтмол мэдэгдэх, заавар зөвлөмж авч байх;</p> <p>2.4. Сайн дурын мэдээллийн тогтолцоог байнга сайжруулах, мэдээллийн эх сурвалжийг чандлан хадгалах ажиллагааг боловсронгуй болгох арга хэмжээг тогтмол авах.</p> <p>2.5. Осол, зөрчлийн мэдээллийн сангийн эх үүсвэрүүдэд тулгуурлан зөрчлийн судалгаа хийж, аюулгүй ажиллагааны шаардлагатай зөвлөмж гаргах;</p> <p>2.6. Болзошгүй осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд олон улсын эрх бүхий байгууллагуудаас гарсан Аюулгүй ажиллагааны зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хүргүүлж байх;</p> <p>2.7. Дотоод, гадаадын шинжлэн шалгах ажиллагааны тайланд үндэслэн гарсан аюулгүй ажиллагааны зөвлөмжийн хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж, жилийн биелэлтийг 60 хувьд хүргэх,</p>	<p>нутагт болсон Монгол Улсын агаарын хөлгийн осол зөрчлийг шалгах ажиллагаанд олон улсын холбогдох эрх зүйн баримт бичгийн хүрээнд оролцох Агаарын хөлгийн осол, ноцтой зөрчлийг давтагдан гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор тус албаны болон гадны ижил төстэй байгууллагын хийж буй шинжлэн шалгах ажлын явцад болон гарсан тайланд үндэслэн, аюулгүй ажиллагааны зөвлөмжийг гаргаж холбогдох байгууллага, хуулийн этгээдэд хүргүүлсэн байна.</p>	<p>Г</p> <p>Г</p> <p>Г</p> <p>Г, Х</p>
3 дугаар зорилтын хүрээнд	<p>3.1. Анализ судалгааны талаар ЗТЯ болон дотоод, гадаадын иргэний нисэхийн байгууллагуудтай хамтран ажиллаж, Монгол Улсын холбогдох хууль дүрэм, заавар, журмын боловсруулалтанд идэвхитэй оролцох;</p> <p>3.2. Шинжлэн шалгах ажиллагааны стандарт, дүрэм, журам зааврыг боловсронгуй болгон ICAO-гийн шаардлагад нийцүүлэн өөрчлөлт шинэчлэлтийг тогтмол хийж байх;</p> <p>3.3. Гадаад улсын шинжлэн шалгах байгууллагуудтай хамтран ажиллах, санамж бичиг байгуулах, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх;</p> <p>3.4. Дотооддоо шинжлэн шалгах чиглэлээр иргэний нисэхийн бусад байгууллагууд, хууль хяналтын байгууллагуудтай хамтран ажиллах;</p> <p>3.5. Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны дотоод үйл ажиллагааг удирдан зохион байгуулах.</p>	<p>Агаарын нөлгийн осол зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны дүрэм, журмын боловсруулалт болон түүний хэрэгжилтийг Чикагогийн Конвенцийн Хавсралт 13 болон Иргэний нисэхийн тухай Монгол Улсын хуулийн хүрээнд явуулсан байна;</p>	<p>Г</p> <p>Г</p> <p>Г, Т</p> <p>Г, Т</p> <p>Г</p>

III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА	
Боловсрол	Магистр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй
Мэргэжил	Нислэгийн удирдагч, нисгэгч, агаарын хөлгийн инженер, агаарын хөлгийн ашиглалтын инженер



Мэргэшил	Байцаагчийн эсвэл шинжлэн шалгагчийн үндсэн сургалтад хамрагдсан байх
Туршлага	Иргэний нисэхийн салбарт 15-аас доошгүй жил ажилласан, хяналт зохицуулалтын чиглэлээр 5-аас доошгүй жил, удирдах албан тушаалд 5-аас доошгүй жил ажилласан
Ур чадвар	<ul style="list-style-type: none"> • хуульд нийцсэн оновчтой, үр дүнтэй шийдвэр гаргах; • маргаан, саналын зөрүүг хууль болон ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхолын зөрчлөөс ангид, эв зүйгээр шийдвэрлэх; • ёс зүйн хэм хэмжээг сахиж, зарчимч, тууштай, ажил хэрэгч чанараараа хамт олондоо үлгэр дууриал үзүүлэх; • ажлын шинэ арга барилыг нэвтрүүлж, хөгжүүлэх, бүтээлч, санаачлагатай ажиллах; • өөрчлөлтийг хийхдээ урьдчилан тооцоолж, манлайлан удирдах; • хувийн зохион байгуулалт, цаг ашиглалтын менежмент сайтай байх; • багаар ажиллах, багийн амжилтыг үнэлэх, дүгнэх, нэгжийн хамт олонд таниулах; • албан хэрэг хөтлөх, баримт бичиг боловсруулах; • компьютерын хэрэглээний программ, интернэт, и-мэйл зэрэг мэдээлэл харилцааны технологийг бүрэн ашиглах чадвартай байх; • мэдээллийг ажилтнуудад тэгш хүргэх; • харилцааны оновчтой арга хэлбэрийг ашиглаж, асуудлыг шийдвэрлэх, мэдээллийг шуурхай хүргэх. • удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж ажиллах. • баримтыг логик үндэслэлтэйгээр шинжлэн шалгах чадвартай байх • байгалийн болон биологийн хүнд хэцүү нөхцөлд шалгалтыг цөхрөлтгүй явуулах чадвартай байх • агаарын хөлгийн осолд өртсөн хүмүүс, байгууллагатай харьцах чадвартай байх • иргэний нисэхийн системийн болон Агаарын хөлгийн системүүд, түүний зориулалтын талаар үйл ажиллагааны өндөр мэдлэгтэй байж, системийн техникийн доголдол, татгалзалыг тогтоох ур чадвартай байх • агаарын хөлгийн нислэг техникийн өгөгдлийн болон онгоц хөдөлгүүрийн найдвартай ажиллагааны хяналтын тусгай программуудыг ашиглаж чаддаг байх • ИКАО-ийн албан ёсны аль нэг хэлний ахисан түвшний мэдлэгтэй байх

IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ	
Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр: – Зам, тээврийн сайд	
Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо: Ахлах шинжлэн шалгагч, шинжлэн шалгагч нар мэргэжилтнүүд, бичиг хэрэг, туслах ажилтан	Бусад харилцах субъект •Зам, тээврийн яам, болон бусад төрийн байгууллагууд •Иргэний нисэхийн удирдах эрх бүхий гадаадын байгууллагууд •Агаарын тээврийн компаниуд •Агаарын хөлгийн эзэмшигчид •Агаарын хөлгийн үйлдвэрлэгч болон зохион бүтээх байгууллагууд



	<ul style="list-style-type: none"> •Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах гадаадын байгууллага •Нислэгийн үйлчилгээний байгууллагууд •Нисэх буудлууд •Ослын газар хамтран ажиллах бусад байгууллага, иргэд
--	---

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ	
Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:
<p>Албан тушаал: .</p> <p>ТӨРИЙН ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА</p> <p>..... Б.БОЛОР-ЭРДЭНЭ</p> <p>2026 оны ... дугаар сарын ... -ны өдөр</p> 	<p>Байгууллагын нэр:</p> <p>ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ</p> <p>Шийдвэрийн огноо:</p> <p>Дугаар:</p> <p>(тамга/тэмдэг)</p> <p>ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД</p> <p>..... Б.ДӨЛГӨРСАЙХАН</p> <p>(Гарын үсэг) (Эцэг/эхийн нэр, өөрийн нэр)</p> <p>2026 оны ... дугаар сарын ... -ны өдөр</p> 





АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 12 сарын 31 өдөр

Дугаар А/10

Улаанбаатар хот

Албан тушаалын тодорхойлолт
батлах тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 103 дугаар зүйлийн 103.3.2 дахь хэсэг, Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны дүрмийн 4.4.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны ажилтнуудын албан тушаалын тодорхойлолтыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү тушаалыг 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

АЛБАНЫ ДАРГА БӨГӨӨД
ЕРӨНХИЙ ШИНЖЛЭН ШАЛГАГЧ *Ж.Цолмон* Ж.ЦОЛМОН



Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн
шалгах албаны даргын 2024 оны 2 сарын
31-ны өдрийн дугаар тушаалын хавсралт



АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН ЖАГСААЛТ

№	Албан тушаалын нэр	Орон тоо
1	Ахлах шинжлэн шалгагч	1
2	Нислэгийн шинжлэн шалгагч	2
3	Техникийн шинжлэн шалгагч	1
4	Нислэгийн хөдөлгөөний шинжлэн шалгагч	1
5	Техникийн шинжлэн шалгагч /Нислэгийн бичлэг/	1
6	Гадаад харилцаа, хуулийн мэргэжилтэн	1
7	Бүртгэл судалгааны мэргэжилтэн	1
8	Санхүү, нягтлан бодогч	1
9	Бичиг хэрэг, туслах ажилтан	1

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон.

Байгууллагын зохион байгуулалтын бүтэц, орон тоонд өөрчлөлт орсон.

Холбогдох хууль тогтоомж, шийдвэрийн нэр, огноо:

Иргэний нисэхийн тухай хууль /шинэчилсэн найрууллага/, Зам, Тээврийн сайдын 2024 оны А/298 дугаар тушаал

Албан тушаалын тодорхойлолтын дугаар:

25.01/01

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

2025 оны 01 дүгээр сарын 02

Байгууллагын нэр:

Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба

Нэгжийн нэр:

Шинжлэн шалгах тасаг

Албан тушаалын нэр:

Ахлах шинжлэн шалгагч

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Ажлын цаг:

Ажлын өдрийн 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Улаанбаатар хот, Хан-Уул, дүүрэг, 21 дүгээр хороо Буянт-Ухаа, Нисэхийн гудамж
Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны байр

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Албан ажлын онцгой нөхцөлд хамаарна

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Монгол улсын нутаг дэвсгэрт гарсан иргэний агаарын хөлгийн осол, зөрчлийг Иргэний нисэхийн тухай Монгол Улсын хуулийн 41,42,43 дугаар зүйлүүд болон Чикагогийн конвенцийн 13 дугаар хавсралтын дагуу шинжлэн шалгаж, шалтгааныг тогтоох энэ төрлийн осол зөрчил давтагдан гарахаас урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн ажлыг гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Албан тушаалын зорилт:

- Агаарын хөлгийн осол, зөрчийг шинжлэн шалгах ажиллагааг удирдан зохион байгуулах, хяналт тавих;
- Шинжлэн шалгах ажиллагааны стандарт, дүрэм, журам зааврыг боловсронгуй болгох;
- Шинжлэн шалгачидийн өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах, мэргэжил мэдлэгийг дээшлүүлэх, хяналт тавих.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр: Туслах (Т) Хариуцан гүйцэтгэх(Г) Хянах (Х) Шийдвэрлэх Ш)
1 дүгээр зорилтын	Агаарын хөлгийн осол, ноцтой зөрчийг шинжлэн шалгах ажиллагааг удирдан зохион байгуулах, хяналт тавих;	Хууль, дүрэм, зааварт нийцсэн байна.	Г, Х

хүрээнд	Агаарын хөлгийн зөрчлийг шинжлэн шалгах ажиллагаанд хяналт тавих;	Хууль, дүрэм, зааварт нийцсэн байна.	Х
	Агаарын хөлгийн осол, зөрчлийн газар дээр ажиллах, шинжлэн шалгах ажиллагаанд хамааралтай ослын үлдэгдэл, бүх төрлийн эд зүйлст хяналтаа тогтоох;	Хууль, дүрэм, зааварт нийцсэн байна.	Х
	Нислэгийн бичлэгийн төхөөрөмж, осол болон ноцтой зөрчилтэй холбоотой агаарын навигацийн үйлчилгээний бичлэг, бусад нотлох баримтыг өөрийн хяналтанд авах;	Хууль, дүрэм, зааварт нийцсэн байна.	Г,Х
	Шинжлэн шалгах ажиллагааны явцад эд мөрийн баримтыг хамгаалах, агаарын хөлөг, түүний үлдэгдэл байгаа бүсэд зөвшөөрөлгүй этгээд нэвтрэх, эд зүйлс үрэгдэж гэмтэх, алдагдахаас хамгаалах боломжит бүх арга хэмжээг авах;	Хууль, дүрэм, зааварт нийцсэн байна.	Г
	Ослын газрыг хамгаалалтад авах асуудлыг эрх бүхий байгууллагад хандаж шийдвэрлүүлэх;	Хууль, дүрэм, зааварт нийцсэн байна.	Т
	Шинжлэн шалгах ажиллагааг гүйцэтгэхэд шаардлагатай ажиглагч, оролцоогүйг тодорхойлох, хуульд заасны дагуу томилох;	Хууль, дүрэм, зааварт нийцсэн байна.	Г, Ш
	Шинжлэн шалгах ажиллагааны явцыг Ерөнхий шинжлэн шалгагчид танилцуулах, осол болон ноцтой зөрчлийн боломжит, шалтгаан, нөлөөлсөн байж болох хүчин зүйлд тулгуурлан аюулгүй байдлын зөвлөмж гаргах ажиллагааг зохион байгуулах;	Хууль, дүрэм, зааварт нийцсэн байна.	Г
	Ослын газрын хамгаалалтыг буулгах, цаашид шинжлэн шалгах ажиллагаанд шаардлагагүй болсон агаарын хөлөг, түүний хэсэг, эд зүйлсийг хадгалалтаас чөлөөлөх;	Хууль, дүрэм, зааварт нийцсэн байна.	Г,Ш
	Шинжлэн шалгах ажиллагааны тайлан гаргах.	Хууль, дүрэм, зааварт нийцсэн байна.	Г
2 дугаар зорилтын хүрээнд	Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенцийн Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах үйл ажиллагааны тухай Хавсралт 13-ийн стандарт, зөвлөмжийг судалж дүрэм, зааварт өөрчлөлт оруулах ажлыг зохион байгуулах;	Гүйцэтгэлийн хэрэгжилт	Г
	Олон улсын байгууллага/ICAO/-оос Хавсралт 13-ийн стандарт, зөвлөмжид өөрчлөлт оруулахаар ирүүлсэн саналыг судлан Ерөнхий шинжлэн шалгагчид танилцуулж хариу өгөх ажлыг зохион байгуулах;	Гүйцэтгэлийн хэрэгжилт	Г
	Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах дүрэмд өөрчлөлт, шинэчлэлт оруулах болон боловсронгуй болгох ажлыг зохион байгуулах;	Гүйцэтгэлийн хэрэгжилт	Г
	Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны дотоод заавруудыг боловсронгуй болгох ажлыг зохион байгуулах;	Гүйцэтгэлийн хэрэгжилт	Г
	Шинжлэн шалгагчийн ёс зүйн дүрэмийг боловсронгуй болгох ажлыг зохион байгуулах.		
3 дугаар зорилтын хүрээнд	Ажлын зохион байгуулалтыг зөв, оновчтой байлгах, ажлын дотоод зохион байгуулалт, ажлын хуваарилалт хийх, ажил байдалд хяналт тавих;	Гүйцэтгэлийн хэрэгжилт	Г
	Шинжлэн шалгагчийн ажлын бүтээмжийг дээшлүүлэх;	Гүйцэтгэлийн хэрэгжилт	Г

гарч болзошгүй агаарын хөлгийн осол зөрчилд шинжлэн шалгах ажиллагааны бэлэн байдлыг хангах;	Гүйцэтгэлийн хэрэгжилт	Г
Шинжлэн шалгах ажиллагааны явц, гүйцэтгэлд хяналт тавих, шаардлагатай дэмжлэгийг үзүүлэх;	Гүйцэтгэлийн хэрэгжилт	Г
шинжлэн шалгагчийн ажлын үр дүнг тодорхойлох;	Гүйцэтгэлийн хэрэгжилт	Г
Шинжлэн шалгагчийн хөдөлмөр хамгаалал, нийгмийн асуудал, мэдлэг чадварыг дээшлүүлэх, тогтвор суурьшилтай ажиллах талаар байнга анхаарч санал хүсэлтээ Ерөнхий шинжлэн шалгагчид хүргэж байх;	Санал бичгээр өгсөн байх	Т,Г
Шинжлэн шалгах ажиллагааны зохион байгуулалт үйл ажиллагааг сайжруулах шинэ, дэвшилтэт арга барилыг судлах, хэрэгжүүлэх талаар холбогдох арга хэмжээг авах;	Гүйцэтгэлийн хэрэгжилт	Г
Зөвлөмжийн хэрэгжилтэнд хяналт тавих ажлыг зохион байгуулах.	Гүйцэтгэлийн хэрэгжилт	Г

III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Баклавр түүнээс дээш зэрэглэлтэй байх	
Мэргэжил	Агаарын хөлгийн инженер эсхүл нисгэгч	
Мэргэшил	Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгагч	
Туршлага	Шинжлэн шалгагчаар 5 аас доошгүй жил ажилласан	
Ур чадвар	Удирдан зохион байгуулах	<ul style="list-style-type: none"> - Шинжлэн шалгах тасгийн үйл ажиллагааг зохион байгуулж үр дүнг тайлагнах - Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах ажиллагааг удирдан зохион байгуулах чадвартай байх - Шинжлэн шалгагчдын нөөцийн бодлого боловсруулах - Шинжлэн шалгагчдын сургалтын бодлогыг боловсруулах - Шинжлэн шалгагчдыг анхан шатны болон ажлын байданд сургаж дадлагажуулах чадвартай байх - Шинжлэн шалгагчдын ажил үүргийг зөв хувиарлах - Албан хаагчтай ижил тэгш харьцах - Шинжлэн шалгах тасгийн дотоод хяналтыг хэрэгжүүлэх
	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> - Албан баримт бичигт дүн шинжилгээ хийх, үнэлэлт, дүгнэлт өгөх чадвартай байх - Иргэний нисэхийн аюулгүй байдлын системийн шинжилгээ хийх, мэдлэг чадвар туршлагатай байх - Агаарын хөлөг түүний эд ангийн бүтэц зохион байгуулалт болон нислэг, техникийн ашиглалтын шинжилгээ хийх мэдлэг, чадвар, туршлагатай, байх - Шинжлэн шалгах ажиллагааны эрсдэлийг урьдчилан тооцох, бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх - Агаарын хөлгийн осол зөрчлийг шинжлэн шалгасан нэгтгэсэн тайланг гаргах дүгнэлтэнд тулгуурлан аюулгүй ажиллагааны зөвлөмж гаргах
	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> - Иргэний нисэхийн тухай Монгол Улсын хууль болон бусад хууль тогтоомжийг чандлан мөрдөж ажиллах. - Асуудлыг албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд хууль болон ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирголоос ангид, оновчтой, шуурхай шийдвэрлэх
	Манлайлах	<ul style="list-style-type: none"> - Шинжлэн шалгагчийн баримтлах ёс зүйн хэм, хэмжээг баримтлах. - Өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцах хамтран ажиллах. - Бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч харилцаа бий болгох - Ажил, мэргэжлийн ур чадвар, ёс зүйгээр хамт олноо үлгэрлэн манлайлах - Ажил хэрэгч, бүтээлч, санаачлагатай ажиллах - Хувийн зохион байгуулалт, ажлын цаг ашиглалтын хувьд хамт олныг

	манлайлах
Бусад	<ul style="list-style-type: none"> - Албан хэрэг хөтлөх, дүрэм, заавар журам боловсруулах. - Шинжлэн шалгасан ажлын тайлан бичих. - Иргэний нисэхийн тухай олон улсын байгууллага/ICAO/-ын хүлээн зөвшөөрсөн аль нэг хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах. - Компьютерын хэрэглээний программ, мэдээллийн технологийн дэвшилтэт аргыг ашиглах. - Хувийн эрүүл мэнд бие бялдрыг хамгаалж, хөгжүүлэн байгалийн хүнд нөхцөлд ажиллах чадвартай байх.

IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:
Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны дарга бөгөөд ерөнхий шинжлэн шалгагч

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо: Шинжлэн шалгагч, 6	<p>Бусад харилцах субъект <i>Шууд харьцах байгууллага:</i></p> <ul style="list-style-type: none"> - Иргэний нисэхийн ерөнхий газар - Агаарын тээврийн компаниуд - Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллага - Нисэх буудлууд - Агаарын хөлгийн эзэмшигчид - Шинжлэн шалгах ажиллагаанд дэмжлэг үзүүлж байгаа байгууллага - Гадаад улсын агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах байгууллага - Осол, зөрчлийн газарт ажиллах бусад байгууллага - Осол, зөрчилтэй холбоотой байгууллага иргэд <p><i>Шууд бус харьцах байгууллага</i></p> <ul style="list-style-type: none"> - Яам, түүний газрууд - Осол, зөрчлийг мөрдөн шалгаж байгаа хууль хяналтын байгууллагуудтай, <p>Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенцийн хэм хэмжээний дагуу</p>
--	---

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:
<p>Албан тушаал: Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны захиргаа</p> <p>..... 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр</p>	<p>Байгууллагын нэр: Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба.</p> <p>Шийдвэрийн огноо: Дугаар:</p>

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр: Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба
Шийдвэрийн огноо:
Дугаар:

(тамга/тэмдэг)



АЛБАНЫ ДАРГА БӨГӨӨД ЕРӨНХИЙ ШИНЖЛЭН ШАЛГАГЧ

Ж.Цолмон

Ж.ЦОЛМОН

2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон.
- Байгууллагын зохион байгуулалтын бүтэц, орон тоонд өөрчлөлт орсон.

Холбогдох хууль тогтоомж, шийдвэрийн нэр, огноо:	Иргэний нисэхийн тухай хууль/Шинэчилсэн найруулга/, Зам, тээврийн сайдын 2024 оны А/298 дугаар тушаал
--	---

Албан тушаалын тодорхойлолтын дугаар:	25.01/ 02
---------------------------------------	-----------

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:	2025 оны . . дүгээр сарын . .-ны өдөр
---	---------------------------------------

Байгууллагын нэр: Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба	Нэгжийн нэр: Шинжлэн шалгах тасаг
Албан тушаалын нэр: Нислэгийн шинжлэн шалгагч	Албан тушаалын ангилал, зэрэглэл: _____
Ажлын цаг: Ажлын өдрийн 8 цаг	Ажлын байрны албан ёсны байршил: ХУД, 21-р хороо, Буянт-Ухаа, Нисэхийн гудамж Агаарын хөлгийн осол зөрчлийг шинжлэн шалгах албаны байр
Хөдөлмөрийн нөхцөл: Хэвийн	Онцгой нөхцөл: Ослын зөрчлийн үед байгаль цаг агаар болон биологийн хүнд нөхцөлд ажиллах.

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Монгол улсын нутаг дэвсгэрт гарсан иргэний агаарын хөлгийн осол, зөрчлийг Иргэний нисэхийн тухай Монгол Улсын хуулийн 9 дүгээр бүлгийн холбогдох заалтууд, Чикагогийн конвенцийн 13 дугаар хавсралтын дагуу шинжлэн шалгаж, шалтгааныг тогтоох энэ төрлийн осол, зөрчил давтагдан гарахаас урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн ажлыг гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Албан тушаалын зорилт:

- Агаарын хөлгийн осол, зөрчилтэй холбоотой мэдээлэл хүлээн авч бүртгэх, ангилах болон мэдээлэх;
- Агаарын хөлгийн осол, зөрчилийг шинжлэн шалгах;
- Шинжлэн шалгах ажиллагааны стандарт, дүрэм, журам болон зааврыг боловсронгуй болгох;
- Мэдээлийн санд тулгуурлан аюулгүй байдлын талаар судалгаа, дүн шинжилгээ хийх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, Оролцооны хэлбэр: Туслах(Т) Хариуцан гүйцэтгэх(Г) Хянах(Х) Шийдвэрлэх(Ш)

1 дүгээр зорилтын хүрээнд	Агаарын хөлгийн осол, зөрчлийн талаар мэдээлэл авах. /24 цагийн жижүүрт хуваарийн дагуу ажиллах/	Гүйцэтгэлийн хэрэгжилт.	Г
	Осол, зөрчлийн мэдээллийг албан ёсны бичиг баримтанд бүртгэх.	Гүйцэтгэлийн хэрэгжилт.	Г
	Осол, зөрчлийн нөхцөл байдлыг судлан урьдчилсан байдлаар ангиллыг тодорхойлох.	Конвенцийн 13 хавсралт, хууль, дүрмэнд нийцсэн байна.	Т,Г
	Осол, ноцтой зөрчлийг ерөнхий болон ахлах шинжлэн шалгагчид нэн даруй мэдээлэх.	Дүрэм, зааварт нийцсэн байна.	Г
	Шаардлагатай гэж үзсэн томоохон зөрчлийг ерөнхий болон ахлах шинжлэн шалгагчид нэн даруй мэдээлэх.	Дүрэм, зааварт нийцсэн байна.	Г
	Удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу осол, ноцтой зөрчлийн мэдээллийг дотоодын болон гадаад улсын холбогдох байгууллагад мэдэгдэх.	Конвенцийн 13-р хавсралт, Хууль, дүрмэнд нийцсэн байна.	Т, Г
2 дугаар зорилтын хүрээнд	Агаарын хөлгийн осол, ноцтой зөрчлийн шинжлэн шалгах ажиллагаанд нислэгийн шинжлэн шалгагчаар ажиллах.	Хууль, дүрэм болон зааварт нийцсэн байна.	Г
	Агаарын хөлгийн зөрчлийг хариуцан шинжлэн шалгах./шинжлэн шалгах багийн ахлахаар ажиллах/	Хууль, дүрэм болон зааварт нийцсэн байна.	Г
	Агаарын хөлгийн осол, зөрчлийн газар дээр ажиллаж, эд, мөрийн баримт цуглуулах.	Хууль, дүрэм болон зааварт нийцсэн байна.	Г
	Осол, зөрчилтэй холбогдолтой байгууллага, аж ахуйн нэгж болон иргэнээс мэдүүлэг болон тодорхойлолт авах.	Хууль, дүрэм болон зааварт нийцсэн байна.	Г
	Осол, зөрчилтэй холбогдолтой байгууллага, аж ахуйн нэгж, иргэний үйл ажиллагаанд үзлэг шалгалт хийх, холбогдох баримт бичгийг авах.	Хууль, дүрэм болон зааварт нийцсэн байна.	Г
	Олж авсан баримт материалуудыг шинжлэн шалгах, лабораторийн дүн шинжилгээ хийлгэх, судлах, боломжит шалтгаан болон нөлөөлсөн хүчин зүйлийг тогтоох.	Дүрэм, зааварт нийцсэн байна	Г
	Осол, зөрчлийн талаар хариуцсан чиг үүргийн дагуу дүгнэлт гаргах.	Зааварт нийцсэн байна	Г
	Осол, зөрчлийн дүгнэлтийг үндэслэн зөвлөмжийн санал боловсруулах.	Зааварт нийцсэн байна.	Т
3 дугаар зорилтын хүрээнд	Шинжлэн шалгах ажиллагааны арга техник, ажлын уялдаа холбоог сайжруулахтай холбогдуулан агаарын хөлгийн осол, ноцтой зөрчлийн шинжлэн шалгах үйл ажиллагаатай холбогдолтой дотоод заавруудад өөрчлөлт шинэчлэлт хийх боловсронгуй болгох санал боловсруулах.	Санал бичгээр өгсөн байх.	Т, Г
	Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны дүрмийг боловсронгуй болгох санал оруулах.	Санал бичгээр өгсөн байна.	Т

	Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны дүрмийг боловсронгуй болгох санал оруулах.	Санал бичгээр өгсөн байна.	Т
	Олон улсын иргэний нисэхийн байгууллага/ИКАО/-с гаргасан аюулгүй байдлын стандарт, зөвлөмж түүний өөрчлөлтүүдтэй танилцаж санал, бодлоо илэрхийлэх.	Санал бичгээр өгсөн байна.	Т
4 дүгээр зорилтын хүрээнд	Агаарын хөлгийн осол, зөрчлийн мэдээллийн санд тулгуурлан судалгаа, шинжилгээ хийх.	Дүрэм, зааварт нийцсэн байна.	Г,Т
	Судалгаанд тулгуурлан шаардлагатай бол дүгнэлт, зөвлөмжийн санал гаргах.	Дүрэм, зааварт нийцсэн байна.	Г,Т

III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА		
Боловсрол	Дээд, тусгай дунд	
Мэргэжил	Агаарын хөлгийн нисгэгч	
Мэргэшил	Шинжлэн шалгагч	
Туршлага	<ul style="list-style-type: none"> Агаарын тээврийн нисгэгчийн үнэмлэх, зэрэглэлтэй (ATPL) байх. Нислэг, нислэгийн удирдлага зохион байгуулалтанд 15-аас доошгүй жил ажилласан. Шинжлэн шалгагчийн сургалтад хамрагдсан байх. 	
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> нислэгийн ашиглалтын аюулгүй байдлын талаар Нислэгийн ашиглалттай холбоотой олж авсан баримт бичигт дүн шинжилгээ хийх, үнэлэлт, дүгнэлт өгөх чадвартай байх. Цаг агаарын мэдээлэл, бичиг баримтанд дүн шинжилгээ хийх, үнэлэлт дүгнэлт өгөх чадвартай байх. Нислэгийн ашиглалтын аюулгүй байдлын бүх түвшний удирдлага, зохион байгуулалтад дүн шинжилгээ хийх, үнэлэлт, дүгнэлт өгөх чадвартай байх Шинжлэн шалгах ажиллагааны арга зүйн мэдлэгтэй байх
	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> Иргэний нисэхийн тухай Монгол улсын хууль болон бусад хууль тогтоомжийг чандлан мөрдөж ажиллах. Албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд хуульд нийцсэн оновчтой шийдвэрийг, шуурхай гаргах. Асуудлыг хууль тогтоомж, ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирголоос ангид шийдвэрлэх. Гаргасан шийдвэрийн талаар хариуцлага хүлээх.
	Манлайлах	<ul style="list-style-type: none"> Шинжлэн шалгагчийн баримтлах ёс зүйн хэм, хэмжээг баримтлах. Өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцах, хамтран ажиллах. Бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч харилцаа бий болгох. Ажил хэрэгч, бүтээлч, санаачлагатай ажиллах. Хувийн зохион байгуулалт, ажлын цаг ашиглалтын хувьд бусдыг манлайлах.
	Бусад	<ul style="list-style-type: none"> Албан хэрэг хөтлөх, дүрэм, заавар журам боловсруулах. Шинжлэн шалгасан ажлын тайлан бичих. Иргэний нисэхийн тухай олон улсын байгууллага/ИКАО/-ын хүлээн зөвшөөрсөн аль нэг хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах. Компьютерын хэрэглээний программ, мэдээллийн технологийн дэвшилтэт аргыг ашиглах. Хувийн эрүүл мэнд, бие бялдарыг хамгаалж, хөгжүүлэн байгалийн хүнд нөхцөлд ажиллах чадвартай байх.

IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ	
Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр: Ахлах шинжлэн шалгагч	
Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо: Шинжлэн шалгах багийн ахлагчаар томилогдсон үед: - Шинжлэн шалгагч - Итгэмжлэгдсэн төлөөлөгч - Зөвлөх - Хуульд заасан бусад этгээд	Бусад харилцах субъект <i>Шууд харьцах байгууллага:</i> - Иргэний нисэхийн ерөнхий газар - Агаарын тээврийн компани - Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллага - Нисэх буудал - Агаарын хөлгийн ашиглагч/эзэмшигчид - Шинжлэн шалгах ажиллагаанд дэмжлэг үзүүлж байгаа байгууллага - Гадаад улсын агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах байгууллага - Осол, зөрчлийн газарт ажиллах бусад байгууллага - Осол, зөрчилтэй холбоотой байгууллага, иргэд <i>Шууд бус харьцах байгууллага</i> - Яам, түүний газрууд, - Осол, зөрчлийг мөрдөн шалгаж байгаа хууль хяналтын байгууллагууд, - Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенцийн хэм хэмжээний дагуу

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ	
Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:
Албан тушаал: Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны ахлах шинжлэн шалгагч Х.НАРАНХҮҮ 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр	Байгууллагын нэр: Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба Шийдвэрийн огноо: 2025 оны . . дүгээр сарын . . -ны өдөр Дугаар:
Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:	
Байгууллагын нэр: АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБА Шийдвэрийн огноо: Дугаар: (тамга/тэмдэг)	
АЛБАНЫ ДАРГА БОГООД ЕРӨНХИЙ ШИНЖЛЭН ШАЛГАГЧ Ж.ЦОЛМОН 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр	

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон.
 Байгууллагын бүтэц зохион байгуулалтын орон тоонд өөрчлөлт орсон.

Холбогдох хууль тогтоомж, шийдвэрийн нэр, огноо: Иргэний нисэхийн тухай хууль/Шинэчилсэн найруулга/, Зам, тээврийн сайдын 2024 оны А/298 дугаар тушаал

Албан тушаалын тодорхойлолтын дугаар: 25.01/03

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо: 2025.02.02

Байгууллагын нэр:
Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба
 Албан тушаалын нэр:
Техникийн шинжлэн шалгагч
 Ажлын цаг:
Ажлын 8 цагаар
 Хөдөлмөрийн нөхцөл:
Хэвийн

Нэгжийн нэр:
Шинжлэн шалгах тасаг
 Албан тушаалын ангилал, зэрэглэл:
-
 Ажлын байрны албан ёсны байршил:
ХУД – 21-р хороо, Буянт –Ухаа, Нисэхийн гудамж, Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны байр.
 Онцгой нөхцөл:
Осол зөрчдийн үед байгаль, цаг агаар болон биологийн хүнд нөхцөлд ажиллах

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:
 Монгол улсын нутаг дэвсгэрт гарсан иргэний агаарын хөлгийн осол, зөрчлийг Иргэний нисэхийн тухай Монгол улсын хуулийн 9 бүлгийн холбогдох заалтууд болон Чикагогийн конвенцийн 13 дугаар хавсралтын дагуу шинжлэн шалгаж, шалтгааныг тогтоох энэ төрлийн осол зөрчил давтагдан гарахаас урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн ажлыг гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

- Албан тушаалын зорилт:
1. Агаарын хөлгийн осол зөрчилтэй холбоотой мэдээлэл хүлээн авч бүртгэх, ангилах болон мэдээллэх,
 2. Агаарын хөлгийн осол зөрчлийг шинжлэн шалгах,
 3. Шинжлэн шалгах ажиллагааны стандарт, дүрэм, журам зааврыг боловсронгуй болгох,
 4. Мэдээллийн санд тулгуурлан аюулгүй байдлын талаар судалгаа, дүн шинжилгээ хийх,

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр: Туслах (Т), Хариуцан гүйцэтгэх (Г) Хянах (Х) Шийдвэрлэх(Ш)
1 дүгээр зорилтын хүрээнд	Агаарын хөлгийн осол, зөрчлийн талаар мэдээлэл авах.(24 цагийн жижүүр хуваарийн дагуу ажиллах)	Гүйцэтгэлийн хэрэгжилт.	Г
	Осол, зөрчлийн мэдээллийг албан ёсны бичиг баримтанд бүртгэх.	Гүйцэтгэлийн хэрэгжилт.	Г

	Осол зөрчлийн нөхцөл байдлыг судлан урьдчилсан байдлаар ангилалыг тодорхойлох.	Конвенцийн 13-р хавсралт, хууль, дүрмэнд нийцсэн байна.	Т,Г
	Осол, ноцтой зөрчлийг ерөнхий болон ахлах шинжлэн шалгагчид нэн даруй мэдээллэх.	Дүрэм, зааварт нийцсэн байна.	Г
	Шаардлагатай гэж үзсэн томоохон зөрчлийг ерөнхий болон ахлах шинжлэн шалгагчид нэн даруй мэдээллэх.	Дүрэм, зааварт нийцсэн байна.	Г
	Удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу осол, ноцтой зөрчлийн мэдээллийг дотоодын болон гадаад улсын холбогдох байгууллагуудад мэдэгдэх.	Конвенцийн хавсралт 13, хууль, дүрмэнд нийцсэн байна.	Т,Г
2 дугаар зорилтын хүрээнд	Агаарын хөлгийн осол, ноцтой зөрчлийн шинжлэн шалгах ажиллагаанд техникийн шинжлэн шалгагчаар ажиллах.	Хууль, дүрэм болон зааварт нийцсэн байна.	Г
	Агаарын хөлгийн зөрчлийг хариуцан шинжлэн шалгах./шинжлэн шалгах багийн ахлагчаар ажиллах/	Хууль, дүрэм болон зааварт нийцсэн байна.	Г
	Агаарын хөлгийн осол, ноцтой зөрчлийн газар дээр ажиллаж , эд мөрийн баримт материал цуглуулах.	Хууль, дүрэм болон зааварт нийцсэн байна.	Г
	Осол, зөрчилтэй холбогдолтой байгууллага, аж ахуйн нэгж болон иргэнээс мэдүүлэг болон тодорхойлолт авах.	Хууль, дүрэм болон зааварт нийцсэн байна.	Г
	Осол, зөрчилтэй холбогдолтой байгууллага аж ахуйн нэгж болон иргэний үйл ажиллагаанд үзлэг шалгалт хийж, холбогдох баримт бичгүүдийг авах.	Хууль, дүрэм болон зааварт нийцсэн байна.	Г
	Олж авсан баримт материалуудыг шинжлэн шалгах, лабораторийн шинжилгээ хийлгэх, судлах, боломжит шалтгаан болон нөлөөлсөн хүчин зүйлийг тогтоох.	Дүрэм, зааварт нийцсэн байна.	Г
	Осол, зөрчлийн талаар хариуцсан чиг үүргийн дагуу дүгнэлт гаргах.	Зааварт нийцсэн байна.	Г
	Осол зөрчлийн дүгнэлтийг үндэслэн зөвлөмжийн санал боловсруулах.	Зааварт нийцсэн байна.	Т
3 дугаар зорилтын хүрээнд	Шинжлэн шалгах ажиллагааны арга техник ажлын уялдаа холбоог сайжруулахтай холбогдуулан агаарын хөлгийн осол, ноцтой зөрчлийг шинжлэн шалгах үйл ажиллагаатай холбогдолтой дотоод зааваруудад өөрчлөлт шинэчлэлт хийх, боловсрогуй болгох, санал боловсруулах	Санал бичгээр өгсөн байх.	Т,Г
	Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны дүрмийг боловсронгуй болгох, санал оруулах.	Санал бичгээр өгсөн байна.	Т
	Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны дүрмийг боловсронгуй болгох, санал оруулах.	Санал бичгээр өгсөн байна.	Т
	Олон улсын байгууллага /ICAO/- с аюулгүй байдлын стандарт, зөвлөмж түүний өөрчлөлтүүдтэй танилцаж санал, бодлоо илэрхийлэх.	Санал бичгээр өгсөн байна.	Т

4 дүгээр зорилтын хүрээнд	Агаарын хөлгийн осол, зөрчлийн мэдээллийн санд тулгуурлан судалгаа, шинжилгээ хийх.	Гүйцэтгэлийн хэрэгжилт.	Т,Г
	Судалгаанд тулгуурлан шаардлагатай бол дүгнэлт, зөвлөмжийн санал гаргах.	Гүйцэтгэлийн хэрэгжилт.	Т,Г


III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА	
Боловсрол	Дээд боловсролын бакалавраас доошгүй зэрэг
Мэргэжил	Агаарын хөлгийн инженер
Мэргэшил	Шинжлэн шалгагчийн сургалт
Туршлага	<ul style="list-style-type: none"> - Агаарын хөлгийн инженерийн мэргэжилтэй байх - Агаарын хөлгийн инженерээр 15-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх - Шинжлэн шалгагчийн сургалтанд хамрагдсан байх

Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> - Агаарын хөлгийн техникийн ашиглалттай баримт бичигт шинжилгээ хийх, техникийн ашиглалтын аюулгүй байдлын талаар үнэлэлт дүгнэлт өгөх чадвартай байх. - Агаарын хөлөг түүний эд ангийн бүтэц зохион байгуулалтанд дүн шинжилгээ хийх мэдлэг, чадвар, туршлагатай байх, - Техникийн ашиглалтын аюулгүй байдлын бүх түвшиний удирдлага зохион байгуулалтад дүн шинжилгээ хийх, үнэлэлт, дүгнэлт өгөх чадвартай байх. - Шинжлэн шалгах ажиллагааны арга зүйн мэдлэг чадвартай байх
	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> - Иргэний нисэхийн тухай Монгол Улсын хууль болон бусад хууль тогтоомжийг чандлан мөрдөж ажиллах. - Албан тушаалийн бүрэн эрхийн хүрээнд хуульд нийцсэн оновчтой шийдвэрийг шуурхай гаргах. - Асуудлыг хууль тогтоомж, ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхолоос ангид шийдвэрлэх. - Гаргасан шийдвэрийн талаар хариуцлага хүлээх.
	Манлайлах	<ul style="list-style-type: none"> - Шинжлэн шалгагчийн ёс зүйн хэм, хэмжээг баримтлах. - Өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцах хамтран ажиллах. - Бусадтай харилцан итгэл төрүүлхүйц ажил хэрэгч харилцаа бий болгох. - Ажил хэрэгч, бүтээлч, санаачлагатай ажиллах. - Хувийн зохион байгуулалт, ажлын цаг ашиглалтын хувьд бусдыг манлайлах.
	Бусад	<ul style="list-style-type: none"> - Албан хэрэг хөтлөх, дүрэм, заавар журам боловсруулах. - Шинжлэн шалгасан ажлын тайлан бичих. - Иргэний нисэхийн тухай олон улсын байгууллага /ICAO/ -ийн хүлээн зөвшөөрсөн аль нэг хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах. - Компьютерын хэрэглээний программ, мэдээллийн технологийн дэвшилтэт аргыг ашиглах. - Хувийн эрүүл мэнд, бие бялдарыг хамгаалж, хөгжүүлэн байгалийн хүнд нөхцөлд ажиллах чадвартай байх.

IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ	
Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр: Ахлах шинжлэн шалгагч	
Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:	Бусад харилцах субъект <i>Шууд харьцах байгууллага:</i>
Шинжлэн шалгах багийн ахлагчаар томилогдсон үед:	<ul style="list-style-type: none"> - Иргэний нисэхийн ерөнхий газар - Агаарын тээврийн компаниуд - Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллага - Нисэх буудлууд - Агаарын хөлгийн эзэмшигчид - Шинжлэн шалгах ажиллагаанд дэмжлэг үзүүлж байгаа байгууллага - Гадаад улсын агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах байгууллага - Осол, зөрчлийн газарт ажиллах бусад байгууллага
<ul style="list-style-type: none"> - Шинжлэн шалгагч - Итгэмжлэгдсэн төлөөлөгч 	

<ul style="list-style-type: none"> - Зөвлөх - Хуульд заасан бусад этгээд 	<ul style="list-style-type: none"> - Осол, зөрчилтэй холбоотой байгууллага иргэд <i>Шууд бус харьцах байгууллага</i> - Яам, түүний газрууд - Осол, зөрчлийг мөрдөн шалгаж байгаа хууль хяналтын байгууллагуудтай, - Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенцийн хэм хэмжээний дагуу
--	--

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:
Албан тушаал: Агаарын хөлгийн шинжлэн шалгах албаны ахлах шинжлэн шалгагч  Х.НАРАНХҮҮ 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр	Байгууллагын нэр: Агаарын хөлгийн шинжлэн шалгах алба Шийдвэрийн огноо: Дугаар:


Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр: Агаарын хөлгийн шинжлэн шалгах алба

Шийдвэрийн огноо:

Дугаар:
(тамга/тэмдэг)

АЛБАНЫ ДАРГА БӨГӨӨД ЕРӨНХИЙ ШИНЖЛЭН ШАЛГАГЧ

Ж.ЦОЛМОН

2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон.

Байгууллагын зохион байгуулалтын бүтэц, орон тоонд өөрчлөлт орсон.

Холбогдох хууль тогтоомж, шийдвэрийн нэр, огноо:

Зам, Тээврийн сайдын 2024 оны А/298
дугаар тушаал

Албан тушаалын тодорхойлолтын дугаар:

АХОЗШША - 25.01/04

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн
шалгах алба

Албан тушаалын нэр:

Техникийн шинжлэн шалгагч

Ажлын цаг:

Ердийн

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Нэгжийн нэр:

Шинжлэн шалгах тасаг

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Ажлын байрны албан ёсны байршил:

ХУД -10 хороо Нисэхийн -1
АХОЗШША

Онцгой нөхцөл:

Ослын газарт байгаль, цаг уурын хүнд болон
биологийн хортой нөхцөлд ажиллана.

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Монгол улсын нутаг дэвсгэрт гарсан иргэний агаарын хөлгийн осол, зөрчлийг Иргэний нисэхийн тухай Монгол Улсын хуулийн 41,42,43 дугаар зүйлүүд болон Чикагогийн конвенцийн 13 дугаар хавсралтын дагуу шинжлэн шалгаж, шалтгааныг тогтоох энэ төрлийн осол зөрчил давтагдан гарахаас урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн ажлыг гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Албан тушаалын зорилт:

- Иргэний агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах;
- Агаарын хөлгийн нислэгийн өгөгдлийн бичлэг, бүхээгийн ярианы бичлэгийг тайлж унших ажлыг зохион байгуулах
- Шинжлэн шалгах ажиллагааны стандарт, дүрэм, журам зааврыг боловсронгуй болгох;
- Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, эрүүл ахуйн зохион байгуулалт;

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах – Т, хариуцан гүйцэтгэх – Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш

1 дүгээр зорилтын хүрээнд	Иргэний агаарын хөлгийн осол, зөрчлийн газар дээр ажиллах, болсон явдлын талаар баримт мэдээлэл цуглуулах;		Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах үйл ажиллагааг	Т, Г
	Баримт материалуудыг судлах, дүн шинжилгээ хийх, боломжит шалтгаан, нөлөөлсөн хүчин зүйлийг тогтоох ажиллагаанд дэмжлэг үзүүлэх		Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ИКАО)-ийн стандарт	Т, Г
	Осол, зөрчлийн талаар дүгнэлт тайлан гаргахад дэмжлэг үзүүлэх		шаардлагын дагуу явуулж (Аннекс-13, Doc)	Т, Г
	Иргэний агаарын хөлгийн осол, зөрчлийн талаар мэдээлэл авах 24 цагийн жижүүрт хуваарийн дагуу ажиллах;		тайлан дүгнэлт гаргасан байна.	Г
2 дугаар зорилтын хүрээнд	Нислэгийн бичлэгийг агаарын хөлгийн бүхээгийн бичигчээс татаж авах ажиллагааг шуурхай зохион байгуулах, лабораторын нөхцөлд нислэгийн өгөгдлийг задлах, параметруудийг тодорхойлох, бичлэгийг хөрвүүлэх, гэмтсэн бичлэгийг сэргээх ажиллагааг боловсронгуй болгох;		Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ИКАО)-ийн стандарт шаардлага, Аннекс, Doc дүрэм журмын хэрэгжилт, үнэн зөв, бодит дүгнэлт гаргасан байна.	Г
	Нислэгийн өгөгдлийг тайлж унших, анализ хийх үйл ажиллагааны дотоодын стандарт, дүрэм, зааврыг боловсронгуй болгох, дагаж мөрдөх, өөрчлөлт шинэчлэлтийг цаг тухайд нь оруулсан байх;		Өөрчлөлт оруулсан баримт бичгийн тоо хэмжээ	Г
	Нислэгийн бичлэг тайлах ажиллагааны арга барил, технологи үйл ажиллагааг сайжруулж, сургалт, дадлагад хамрагдаж, мэдлэг чадвараа дээшлүүлэх		Үйл ажиллагааны тоо хэмжээ, мэдлэг чадвараа дээшлүүлсэн байдал	Г
3 дугаар зорилтын хүрээнд	Олон улсын байгууллагаас ирсэн баримт бичгийн өөрчлөлтүүдтэй танилцаж санал бодлоо илэрхийлэх;		Өөрчлөлт оруулсан, санал гаргасан баримт бичгийн тоо хэмжээ	Т, Г
	Шинжлэн шалгах ажиллагааны арга техник, ажлын уялдаа холбоог сайжруулахтай холбогдуулан дүрэм, журам, зааварт шинэчлэлт өөрчлөлт оруулах талаар санал гаргах;			Т, Г
4 дүгээр зорилтын хүрээнд	Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, эрүүл ахуйн бодлого төлөвлөгөөг боловсруулах, дүрэм журмыг шинэчлэхэд дэмжлэг үзүүлэх;		Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, эрүүл ахуйн хууль тогтоомжийг хэрэгжүүлсэн байна.	Т, Г
	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн шаардлага, стандарт, байгууллагын мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм, журмыг хэрэгжүүлэх, зөрчил дутагдалгүй ажиллах;			Т, Г
	Ажлын нөхцөл, мэргэжлийн онцлогт тохирсон тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг ашиглах, чанар, зохистой хэрэглээг нэвтрүүлэх;			Т, Г
III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА				
Боловсрол	Дээд боловсрол, магистрийн зэрэг			
Мэргэжил	Агаарын хөлгийн инженер, техник			
Мэргэшил	Техникийн анализ судалгааны инженер			
Туршлага	<ul style="list-style-type: none"> Агаарын хөлгийн техникийн инженерийн үнэмлэхтэй Засвар үйлчилгээ гүйцэтгэх болон засвар үйлчилгээний хяналт шалгалтын ажлыг 10-аас дээш жил хийсэн туршлагатай байх, Агаарыг хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах байгууллагад 5-с дээш жил ажилласан туршлагатай байх 			
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> Баримтыг логик үндэслэлтэйгээр шинжлэн шалгах чадвартай байх Байгалийн болон биологийн хүнд хэцүү нөхцөлд шалгалтыг цөхрөлтгүй явуулах чадвартай байх 		
	Асуудал	- Агаарын хөлгийн осолд өртсөн хохирогчидтой харьцах чадвартай		

шийдвэрлэх	байх - Нууц хадгалах
Манлайлах	- Үнэнч шударга, зарчимч байх - Ашиг сонирхлын зөрчилгүй, ёс зүйн зөрчилгүй байх
Бусад	- Компьютерийн өргөн хэрэглээний программуудыг ашиглаж чаддаг байх - Орос, англи хэлний зохих мэдлэгтэй байх

IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

1. Албаны дарга бөгөөд ерөнхий шинжлэн шалгагч
2. Ахлах шинжлэн шалгагч

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

1. Бүртгэл судалгааны мэргэжилтэн
2. Бичиг хэрэг, туслах ажилтан

Бусад харилцах субъект


- Иргэний нисэхийн ерөнхий газар
- Агаарын тээврийн компаниуд
- Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллага
- Нисэх буудлууд
- Агаарын хөлгийн эзэмшигчид
- Гадаад улсын агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах байгууллага
- Осол, зөрчлийн газарт ажиллах бусад байгууллага

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:

Албан тушаал:
АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ АХЛАХ ШИНЖЛЭН ШАЛГАГЧ

 Х.НАРАНХҮҮ

Байгууллагын нэр: АХОЗШША

Шийдвэрийн огноо:

Дугаар:

2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр: АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБА

Шийдвэрийн огноо:

Дугаар:
(тамга/тэмдэг)

АЛБАНЫ ДАРГА БӨГӨӨД ЕРӨНХИЙ ШИНЖЛЭН ШАЛГАГЧ





Ж.ЦОЛМОН

2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон.

Байгууллагын зохион байгуулалтын бүтэц, орон тоонд өөрчлөлт орсон.

Холбогдох хууль тогтоомж, шийдвэрийн нэр, огноо:	Иргэний нисэхийн тухай хууль/Шинэчилсэн найруулга/, Зам, Тээврийн сайдын 2024 оны А/298 дугаар тушаал
Албан тушаалын тодорхойлолтын дугаар:	25.01/05

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:	2025 оны 01 дүгээр сарын 05 ны өдөр
---	-------------------------------------

Байгууллагын нэр: Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба

Албан тушаалын нэр: Нислэгийн хөдөлгөөний шинжлэн шалгагч
--

Ажлын цаг: Ажлын өдрийн 8 цаг

Хөдөлмөрийн нөхцөл: Хэвийн

Нэгжийн нэр: Шинжлэн шалгах тасаг

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Ажлын байрны албан ёсны байршил: ХУД, 21-р хороо, Нисэхийн гудамж Агаарын хөлгийн осол зөрчлийг шинжлэн шалгах албаны байр
--

Онцгой нөхцөл: Ослын зөрчлийн үед байгаль цаг агаар болон биологийн хүнд нөхцөлд ажиллах.
--

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Монгол улсын нутаг дэвсгэрт гарсан иргэний агаарын хөлгийн осол, зөрчлийг Иргэний нисэхийн тухай Монгол Улсын хуулийн 9 дүгээр бүлгийн холбогдох заалтууд Чикагогийн конвенцийн 13 дугаар хавсралтын дагуу шинжлэн шалгаж, шалтгааныг тогтоох энэ төрлийн осол, зөрчил давтагдан гарахаас урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн ажлыг гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Албан тушаалын зорилт:

- Агаарын хөлгийн осол, зөрчилтэй холбоотой мэдээлэл хүлээн авч бүртгэх, ангилах, болон мэдээлэх.
- Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах.
- Шинжлэн шалгах ажиллагааны стандарт, дүрэм, журам зааврыг боловсронгуй болгох.
- Мэдээлийн санд тулгуурлан аюулгүй байдлын талаар судалгаа дүн шинжилгээ хийх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр: Туслах (Т) хариуцан гүйцэтгэх (Г) Хянах (Х) Шийдвэрлэх(Ш)
1 дүгээр зорилтын хүрээнд	Агаарын хөлгийн осол, зөрчлийн талаар мэдээлэл авах. /24 цагийн жижүүрт хуваарийн дагуу ажиллах/	Гүйцэтгэлийн хэрэгжилт.	Г
	Осол, зөрчлийн мэдээллийг албан ёсны бичиг баримтанд бүртгэх.	Гүйцэтгэлийн хэрэгжилт.	Г

	Осол, зөрчлийн нөхцөл байдлыг судлан урьдчилсан байдлаар ангиллыг тодорхойлох.	Конвенцийн 13-р хавсралт, хууль дүрмэнд нийцсэн байна.	Т, Г
	Осол, ноцтой зөрчлийг ерөнхий болон ахлах шинжлэн шалгагчид нэн даруй мэдээлэх.	Дүрэм, зааварт нийцсэн байна.	Г
	Шаардлагатай гэж үзсэн томоохон зөрчлийг ерөнхий болон ахлах шинжлэн шалгагчид нэн даруй мэдээлэх.	Дүрэм, зааварт нийцсэн байна.	Г
	Удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу осол, ноцтой зөрчлийн мэдээллийг дотоодын болон гадаад улсын холбогдох байгууллагад мэдэгдэх.	Конвенцийн 13-р хавсралт, хууль дүрмэнд нийцсэн байна.	Т, Г
2 дугаар зорилтын хүрээнд	Агаарын хөлгийн осол, ноцтой зөрчлийн шинжлэн шалгах ажиллагаанд нислэгийн хөдөлгөөний шинжээчээр ажиллах.	Хууль, дүрэм болон зааварт нийцсэн байна.	Г
	Агаарын хөлгийн зөрчлийг хариуцан шинжлэн шалгах./шинжлэн шалгах багийн ахлахаар ажиллах/	Хууль, дүрэм болон зааварт нийцсэн байна.	Г
	Агаарын хөлгийн осол, ноцтой зөрчлийн газар дээр ажиллаж, эд, мөрийн баримт цуглуулах.	Хууль, дүрэм болон зааварт нийцсэн байна.	Г
	Осол, зөрчилтэй холбогдолтой байгууллага, аж ахуйн нэгж болон иргэнээс мэдүүлэг болон тодорхойлолт авах.	Хууль, дүрэм болон зааварт нийцсэн байна.	Г
	Осол, зөрчилтэй холбогдолтой байгууллага, аж ахуйн нэгж, иргэний үйл ажиллагаанд үзлэг шалгалт хийх, холбогдох баримт бичгийг авах.	Хууль, дүрэм болон зааварт нийцсэн байна.	Г
	Олж авсан баримт материалуудыг шинжлэн шалгах, лабораторийн дүн шинжилгээ хийлгэх, судлах, боломжит шалтгаан болон нөлөөлсөн хүчин зүйлийг тогтоох.	Зааварт нийцсэн байна.	Г
	Осол, зөрчлийн талаар хариуцсан чиг үүргийн дагуу дүгнэлт гаргах.	Зааварт нийцсэн байна.	Г
	Осол, зөрчлийн дүгнэлтийг үндэслэн зөвлөмжийн санал боловсруулах.	Зааварт нийцсэн байна.	Т
3 дугаар зорилтын хүрээнд	Шинжлэн шалгах ажиллагааны арга техник, ажлын уялдаа холбоог сайжруулахтай холбогдуулан агаарын хөлгийн осол, ноцтой зөрчлийн шинжлэн шалгах үйл ажиллагаатай холбогдолтой дотоод зааваруудад өөрчлөлт шинчлэлт хийх боловсронгуй болгох санал боловсруулах.	Санал бичгээр өгсөн байх.	Т, Г
	Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба дүрмийг боловсронгуй болгох, санал оруулах.	Санал бичгээр өгсөн байна.	Т
	Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны дүрмийг боловсронгуй болгох, санал оруулах.	Санал бичгээр өгсөн байна.	Т
	Олон улсын иргэний нисэхийн байгууллага/ИКАО/-с гаргасан аюулгүй байдлын стандарт, зөвлөмж түүний өөрчлөлтүүдтэй танилцаж санал бодлоо илэрхийлэх.	Санал бичгээр өгсөн байна.	Т
4 дүгээр	Агаарын хөлгийн осол, зөрчлийн мэдээллийн санд тулгуурлан судалгаа, шинжилгээ хийх.	Гүйцэтгэлийн хэрэгжилт.	Г,Т

зорилтын хүрээнд	Судалгаанд тулгуурлан шаардлагатай бол дүгнэлт, зөвлөмжийн санал гаргах.	Гүйцэтгэлийн хэрэгжилт.	Г,Т
------------------	--	-------------------------	-----

III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Дээд, тусгай дунд	
Мэргэжил	Нислэгийн хөдөлгөөний удирдагч	
Мэргэшил	Шинжлэн шалгагч	
Туршлага	<ul style="list-style-type: none"> - Нислэгийн хөдөлгөөний удирдагчийн мэргэжилтэй. - Нислэгийн хөдөлгөөний удирдагч, холбоо, навигаци, цаг уурын чиглэлээр 15-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх. - Шинжлэн шалгачийн сургалтанд хамрагдсан байх 	
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> - Осол, зөрчилтэй холбоотой олж авсан бүх нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний чиглэлийн баримт бичигт дүн шинжилгээ хийх, үнэлэлт, дүгнэлт өгөх чадвартай байх. - Цаг агаарын мэдээлэл, бичиг баримтанд дүн шинжилгээ хийх, үнэлт дүгнэлт өгөх чадвартай байх. - Нислэгийн хөдөлгөөний аюулгүй байдлын бүх түвшинь удирдлага зохион байгуулалтад дүн шинжилгээ хийх, үнэлэлт, дүгнэлт өгөх чадвартай байх. - Шинжлэн шалгах ажиллагааны арга зүйн мэдлэг чадвартай байх.
	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> - Иргэний нисэхийн тухай Монгол Улсын хууль болон бусад хууль тогтоомжийг чандлан мөрдөж ажиллах. - Албан тушаалийн бүрэн эрхийн хүрээнд хуульд нийцсэн оновчтой шийдвэрийг, шуурхай гаргах. - Асуудлыг хууль тогтоомж, ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхолоос ангид шийдвэрлэх. - Гаргасан шийдвэрийн талаар хариуцлага хүлээх.
	Манлайлах	<ul style="list-style-type: none"> - Шинжлэн шалгагчийн баримтлах ёс зүйн хэм, хэмжээг баримтлах. - Өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцах хамтран ажиллах. - Бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч харилцаа бий болгох. - Ажил хэрэгч, бүтээлч, санаачлагатай ажиллах. - Хувийн зохион байгуулалт, ажлын цаг ашиглалтын хувьд бусдыг манлайлах.
	Бусад	<ul style="list-style-type: none"> - Албан хэрэг хөтлөх, дүрэм, заавар журам боловсруулах. - Шинжлэн шалгасан ажлын тайлан бичих. - Иргэний нисэхийн тухай олон улсын байгууллага/ICAO/-ын хүлээн зөвшөөрсөн аль нэг хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах. - Компьютерын хэрэглээний программ, мэдээллийн технологийн дэвшилтэт аргыг ашиглах. - Хувийн эрүүл мэнд бие бялдарыг хамгаалж, хөгжүүлэн байгалийн хүнд нөхцөлд ажиллах чадвартай байх.

IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр: Ахлах шинжлэн шалгагч

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:	Бусад харилцах субъект
Шинжлэн шалгах багийн ахлагчаар томилогдсон үед:	<i>Шууд харьцах байгууллага:</i>
<ul style="list-style-type: none"> - Шинжлэн шалгагч - Итгэмжлэгдсэн төлөөлөгч 	<ul style="list-style-type: none"> - Иргэний нисэхийн ерөнхий газар - Агаарын тээврийн компаниуд - Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллага - Нисэх буудлууд - Агаарын хөлгийн эзэмшигчид - Шинжлэн шалгах ажиллагаанд дэмжлэг үзүүлж байгаа байгууллага - Гадаад улсын агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах байгууллага

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон.
- Байгууллагын зохион байгуулалтын бүтэц, орон тоонд өөрчлөлт орсон.

Холбогдох хууль тогтоомж, шийдвэрийн нэр, огноо:

Иргэний нисэхийн тухай хууль/Шинэчилсэн найруулга/, Зам, Тээврийн сайдын 2024 оны А/298 дугаар тушаал

Албан тушаалын тодорхойлолтын дугаар:

25/06

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

2025 оны 07 дүгээр сарын 22-ны өдөр

Байгууллагын нэр:

Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба

Нэгжийн нэр:

Захиргаа, судалгааны тасаг

Албан тушаалын нэр:

Бүртгэл, судалгааны мэргэжилтэн

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Ажлын цаг:

Ажлын 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Улаанбаатар хот, ХУД, 21-р хороо, Буянт-Ухаа, Нисэхийн гудамж Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн албаны байр 105 т

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Ослын зөрчлийн үед байгаль цаг агаар болон биологийн хүнд нөхцөлд өдөр болон шөнө цаг хязгаарлахгүй ажиллах.

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Монгол улсын нутаг дэвсгэрт гарсан иргэний агаарын хөлгийн осол, зөрчлийг Иргэний нисэхийн тухай Монгол Улсын хуулийн 9-р бүлгийн холбогдох заалтууд болон Чикагогийн конвенцийн 13 дугаар хавсралтын дагуу шинжлэн шалгаж, шалтгааныг тогтоох энэ төрлийн осол зөрчил давтагдан гарахаас урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн ажлыг гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Албан тушаалын зорилт:

- Нислэг, техникийн осол, зөрчлийн мэдээллийг авах, бүртгэх, мэдээллийн сан бүрдүүлэх;
- Агаарын хөлгийн осол, зөрчлийн тайлан, аюулгүй байдлын зөвлөмжийг бүртгэх, түгээх, хэрэгжилтийн явц, хугацаанд хяналт тавих, зөвлөмжийн биелэлт гаргах;
- Захиргаа, судалгааны тасгийн дотоод үйл ажиллагаанд оролцох.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах – Т, хариуцан гүйцэтгэх – Г Хянах – Х

			Шийдвэрлэх – Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	Осол, зөрчлийг ангилах, бүртгэх, мэдээллийн сан бүрдүүлэх.	Мэдээллийг бүрэн авч, ангилан бүртгэж, санг хөтөлнө.	Г
	Осол, зөрчлийн бүртгэлээс сар тутам тайлан гаргах, жилийн эцэст бодит график дүрслэлд харуулсан танилцуулга гаргах, статистик судалгаа хийх.	Осол, зөрчлийг бүртгэх, мэдээлэх ажиллагааг бүрэн гүйцэт хийх, цахим хуудсаар мэдээлэл дамжуулах үйл ажиллагааг сайжруулсан байна.	Г
	Олон улсын мэдээллийн сангаас осол, ноцтой зөрчлүүдийн талаарх мэдээллийг авах, шаардлагатай мэдээллээр хангах.	ОУИНБ-с агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах талаар тавигдаж байгаа зорилго, ач холбогдлыг олон нийтэд танилцуулах.	Г
2 дугаар зорилтын хүрээнд	Агаарын хөлгийн осол, зөрчлийн талаар шинжлэн шалгасан тайланг бүртгэлд авах холбогдох газруудад албан бичгээр хүргүүлж, санал авах ажлыг зохион байгуулах, тайлантай холбогдуулж ирсэн саналыг бүртгэх.	Шинжлэн шалгасан тайланг холбогдох газруудад илгээж санал авч, бүртгэлд оруулсан байх.	Г
	Тайланг бүртгэх, хувилах олшруулах арга хэмжээг зохион байгуулах, гадаад дотоодын холбогдох байгууллага, иргэдэд илгээх, хадгалах, үндсэн хувийг нотлох баримтуудын хамт архивлах.	Эцсийн тайланг холбогдох байгууллагуудад болон шаардлагатай тохиолдолд Олон улсын иргэний нисэхийн байгууллагуудад /ОУИНБ/-д англи хэл дээр хөрвүүлэн хүргүүлэх, албаны цахим хуудсанд байршуулах.	Г
	Осол, зөрчлийг дахин давтагдан гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор гаргасан Аюулгүй байдлын зөвлөмжийг бүртгэлд оруулах, зөвлөмжийг холбогдох байгууллагуудад илгээх.	Аюулгүй байдлын зөвлөмжийг бүртгэлд оруулах, холбогдох байгууллагуудад илгээсэн байх.	Г
	Дүрэмд заасны дагуу гурван сар тутамд аюулгүй байдлын зөвлөмжийн хэрэгжилтийг бүртгэлээр хянах, хэрэгжилтийн тайланг холбогдох байгууллагуудаас гаргуулж авах, шаардлагатай бол зөвлөмжийн талаар хэлэлцэх ажлыг зохион байгуулах.	Аюулгүй ажиллагааны зөвлөмжийн хэрэгжилтийг бүртгэн авч, хэрэгжилтэд хяналт тавьж, ЗТЯ-нд улирал бүр танилцуулсан байх.	Г
	Шинжлэн шалгагч нарын хөдөлмөр хамгаалал, хувцас, хэрэглэлийн бүрэн бүтэн байдлыг хангах, багаж хэрэгслийг бүртгэх, хадгалах, байнгын бэлэн байдалд байлгах.	Нормын дагуу бэлтгэж, бэлэн байдалд байлгана. Нэмэлт шаардлагатай төсвийг төсөвт тусгуулсан байх.	Г
	Автокад, 3D программаар тайлантай холбоотой, үзүүлэн, дүрслэлүүдийг гаргахад шинжлэн шалгагч нарт тусалцаа үзүүлэх.	Автокад, 3D программыг эзэмшсэн байх.	Г, Г
	Албаны www.aair.gov.mn цахим хуудасны ажиллагааг өдөр тутам шалгаж мэдээллүүдийг шинэчилж байх.	Мэдээллийг цахим хуудсанд тогтмол байршуулж байх.	Г
3 дугаар зорилтын хүрээнд	Цахим хуудас, имэйлээр ирсэн осол, зөрчлийн мэдээллүүдийг авч, бүртгэх.	Ирсэн мэдээллүүдийг шалгаж, бүртгэн сан үүсгэсэн байх.	Г
	Шинээр нэвтрүүлж буй тоног төхөөрөмжийг ашиглах талаар	Холбогдох дүрэм, зааврын дагуу хийгдсэн байна.	Г

	зааварчилгаатай танилцах, судлах, тохиргоо хийх, ажилтнуудад ашиглалтын талаар зааварчилга өгөх, багаж хэрэгслийн эвдрэл, гэмтлийн үед засварлах, сэлбэг, материалын захиалга хийх, төлбөр хураамжийг барагдуулах ажлыг гүйцэтгэх.		
	Албанаас гаргасан албан тоот, томилолт, тушаал бичиг баримтуудыг бүртгэх, түгээх, архив, бусад.	Холбогдох дүрэм, зааврын дагуу хийгдсэн байна.	Г
	Албаны үйл ажиллагааны цахим шилжилтийг гүйцэтгэх, тоон гарын үсэг нэвтрүүлэх.	Ажилтнуудын тоон гарын үсгийн хэрэглээг албан бичиг хөтлөлтөд нэвтрүүлэх, хэрэглээг нэмэгдүүлж, бүрэн ашигласан байна.	Г
	Мэдээллийн аюулгүй байдал, цахимжуулалтын үйл ажиллагааг хариуцах	Мэдээллийн аюулгүй байдал, цахимжуулалтын үйл ажиллагааг сайжруулсан байна.	Г, Х

III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА		
Боловсрол	Дээд боловсролын бакалаврын зэрэгтэй байх эсвэл тус албанд 5-с доошгүй жил бичиг хэрэг, туслах ажилтнаар ажилласан байх	
Мэргэжил	Инженер, техник	
Мэргэшил	<ul style="list-style-type: none"> • ECCAIRS системд суралцаж дадлагажсан байх • Автокад програмийг эзэмшсэн байх 	
Туршлага	Төрийн болон хувийн байгууллагад 5-аас доошгүй жил ажилласан, ажлын зохих туршлагатай байх	
Тусгай шаардлага	<ul style="list-style-type: none"> • Үнэнч шударга, зарчимч байх • Нууц хадгалах • Ашиг сонирхлын зөрчилгүй • Ёс зүйн зөрчилгүй 	
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> • Мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх; • Гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах; • Судалгааны ерөнхий арга зүйн мэдлэгтэй байх.
	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> • Өөрийн чиг үүргийн хүрээнд шийдлийн хувилбарыг боловсруулж, хариуцах; • Шаардлагатай асуудлаар судалгаа хийж, дүнг хариуцах.
	Багаар ажиллах чадвар	<ul style="list-style-type: none"> • Өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах; • Бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох.
	Бусад	<ul style="list-style-type: none"> • Англи хэлний зохих мэдлэгтэй байх; • Компьютерийн хэрэглээний болон тусгай программууд дээр ажиллах чадвартай байх; • Албан хэрэг хөтлөх, баримт бичиг боловсруулах.

IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ
Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:
<ul style="list-style-type: none"> • Албаны дарга бөгөөд ерөнхий шинжлэн шалгагч • Ахлах шинжлэн шалгагч

<p>Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:</p> <ul style="list-style-type: none"> • Бичиг хэрэг, туслах ажилтан • Технологийн жолооч 	<p>Бусад харилцах субъект Шууд харьцах байгууллага:</p> <ul style="list-style-type: none"> • ИНЕГ, түүний харьяа салбар, нэгжүүд, • Нисэх буудлууд, • Агаарын тээврийн компаниуд, • Агаарын хөлгийн эзэмшигчид, • Ажил хэргийн хүрээнд харилцах бусад төрийн болон төрийн бус байгууллага, иргэд <p>Шууд бус харьцах байгууллага:</p> <ul style="list-style-type: none"> • Зам, тээврийн яам, • Гадаад улсын агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах байгууллага /AAIB/, • Европын холбооны осол, зөрчлийн мэдээллийн систем /ECCAIRS/
---	--

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

<p>Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:</p>	<p>Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:</p>
<p>Албан тушаал: АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ АХЛАХ ШИНЖЛЭН ШАЛГАГЧ Х.НАРАНХҮҮ 2025 оны 07 дүгээр сарын 02-ны өдөр</p>	<p>Байгууллагын нэр: АХОЗШША Шийдвэрийн огноо: Дугаар:</p>
<p>Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:</p>	
<p>Байгууллагын нэр: АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБА Шийдвэрийн огноо: Дугаар: (тамга/тэмдэг)</p> <p>АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ ДАРГА БӨГӨӨД ЕРӨНХИЙ ШИНЖЛЭН ШАЛГАГЧ Ж.ЦОЛМОН 2025 оны 07 дүгээр сарын 02-ны өдөр</p>	

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо: Зам, Тээврийн сайдын 2024 оны А/298 дугаар тушаал

Дагаж мөрдөх огноо: АХОЗШША - 25-01.02 (25/07)

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо: 2025. 01.02

Байгууллагын нэр:

Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба

Нэгжийн нэр:

Захиргаа, судалгааны тасаг

Албан тушаалын нэр:

Санхүү, нягтлан бодогч

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Ажлын цаг:

Ажлын өдөр 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

ХУД, 10-р хороо, Нисэхийн гудамж, АХОЗШША

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй.

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Албаны нягтлан бодох бүртгэлийн өдөр тутмын үйл ажиллагааг тасралтгүй үнэн зөв бүртгэх, өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалт, ашиглалтад бүртгэлээр хяналт тавих, санхүүгийн тайлан тэнцэл гаргах, бүртгэлийг зөрчил дутагдалгүй хөтлөх.

Албан тушаалын зорилт:

1. Байгууллагын нягтлан бодох бүртгэлийн өдөр тутмын үйл ажиллагааг бүртгэх, тайлагнах, орлого зардлын төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлд хяналт тавих;
2. Байгууллагын өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтанд бүртгэлээр хяналт тавих;
3. Мэдээ, тайлан, судалгааг тогтоосон хугацаанд нь гаргаж удирдлагад танилцуулах;
4. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж, стандартыг хэрэгжүүлэх;

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах - Х Шийдвэрлэх - Ш

1 дүгээр зорилтын хүрээнд	<p>1.1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд заасны дагуу ерөнхий нягтлан бодогчийн эрх үүргийг хэрэгжүүлэн ажиллах;</p> <p>1.2. Батлагдсан орлого, зарлагын төлөвлөгөөний дагуу эдийн засгийн ангиллын суурийг дагаж мөрдөн зөв бүртгэх;</p> <p>1.3. Харилцагч арилжааны банкинд баталгаажсан төлбөрийн даалгаврын дагуу шилжүүлгийг хийх, гүйлгээ гарсан өдөр тутмын хуулгыг авч, зохих баримттай тулган шалгах, баталгаажуулах, зөрүү илэрвэл харилцагч банкинд мэдэгдэж алдааг залруулах;</p> <p>1.4. Байгууллагын санхүүжилтийн орлогыг цаг хугацаанд нь бүртгэх;</p> <p>1.5. Албан хаагчдын цалинг Хөдөлмөрийн дотоод журамд заасан хугацаанд олгох;</p> <p>1.6. Нийгмийн даатгалын болон татварын тооцоо тайланг хуулийн хугацаанд гаргаж тайлагнах;</p> <p>1.7. Байгууллагын мөнгөн хөрөнгийн гүйлгээний анхан шатны баримтын бүрдлийг сайтар хангаж, холбогдох дансны бүртгэлийг үнэн зөв хөтлөх, тайлан гаргах;</p> <p>1.8. Мөнгөн суурьт болон аккруэл суурьт шалгах балансыг гаргаж санхүүжилтийн тооцоог дараа сарын 03-ны дотор хийх;</p> <p>1.9. Үндсэн болон эргэлтийн хөрөнгийг бүртгэлд бүртгэх, эзэмшигч бүрт хариуцуулан карт хөтөлж бүртгэлээр хяналт тавьж ажиллах;</p> <p>1.10. Эд хөрөнгө, өр авлага, ажил гүйлгээ, төлбөрийг хүчин төгөлдөр бус баримтаар бүртгэхгүй байх;</p> <p>1.11. Нягтлан бодох бүртгэлийн дансны бичилт, ерөнхий журнал болон ерөнхий дэвтрийн хөтлөлтийг үнэн зөв бүртгэх;</p> <p>1.12. Харилцагч байгууллагатай үүссэн авлага, өглөгийн тооцоог хийж, актаар баталгаажуулах, өр, авлагыг тухай бүр барагдуулж ажиллах;</p> <p>1.13. Бараа, ажил үйлчилгээний худалдан авалтын нэмэгдсэн өртгийн албан татварын тооцоог хуулийн хугацаанд хийж тайлагнах;</p> <p>1.14. Хагас жил болон жилийн эцсийн санхүүгийн тайланг дансны үлдэгдлийн баталгаа, хөрөнгийн тооллогын акт, холбогдох хавсралт тодруулга тайлан мэдээг хавсарган баталгаажуулан хугацаанд нь хүргүүлэх;</p> <p>1.15. Дараа жилийн орлого, зардлын төсвийн саналыг боловсруулах, хүргүүлэх, батлагдсан орлого, зардлын төсвийг хуваарилан гүйцэтгэлийг сар, улирал бүрээр гаргах, хяналт тавих, удирдлагыг мэдээллээр хангах;</p> <p>1.16. Сар бүрийн төсвийн гүйцэтгэлийг гаргаж санхүүжилтийн тооцоог хийх;</p>	Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа хэвийн явагдсан байна.	Г Г Г Г Г Г Г Г, X Г Г Г Г Г, X Г
2 дугаар зорилтын хүрээнд	<p>2.1. Байгууллагын үндсэн ба эргэлтийн хөрөнгийн зүй зохистой хэмжээнд хяналт тавих;</p> <p>2.2. Ажилтнуудад нормоор олгож буй бараа материал, байгууллагад мөрдөж буй норм, нормативын гүйцэтгэлд хяналт тавьж, батлагдсан нормыг хянаж олгох;</p> <p>2.3. Бараа материал, сэлбэг, үндсэн хөрөнгийн худалдан авалт, зарцуулалтад хяналт тавьж баталгаажуулах ба холбогдох санхүүгийн баримтанд гарын үсэг зурах;</p> <p>2.4. Байгууллагын өмч хөрөнгийн хагас, бүтэн жилийн тооллогод биечлэн оролцох, тооллогыг чанартай хийж гүйцэтгэх, тооцоо бодсон акт үйлдэх, хяналт тавих ;</p> <p>2.5. Ашиглалтын хугацаа дууссан, цаашид ашиглах боломжгүй болсон хөрөнгийг ашиглалтаас хасах баримтыг бүрдүүлэн төрийн өмчийн асуудал эрхэлсэн байгууллагад асуудлыг тавьж шийдвэрлүүлэх;</p> <p>2.6. Шаардлагатай үед гэнэтийн тооллого хийж, өмч хөрөнгө илүүдэл, дутагдалтай холбоотой илэрсэн зөрчлийг тухай бүр тооцоо бодсон актаар баталгаажуулах, шийдвэрлүүлэх;</p>	Байгууллагын хөрөнгө зөв зохистой зарцуулагдаж санхүүгийн зөрчил дутагдалгүй ажилласан байна.	Г, X Г, X Г Г, X Г, X Г, X Г, X

3 дугаар зорилтын хүрээнд	<p>3.1. НББОУС, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан стандарт, журам, зааварт заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэлийг зөв хөтлөх, санхүүгийн тайланг хагас жил, бүтэн жилээр гаргаж хуулийн хугацаанд холбогдох байгууллагуудад тайлагнах;</p> <p>3.2. Нийгмийн даатгалын тайланг сар бүрийн 05-ны дотор гарган тайлагнах, нийгмийн даатгалын байгууллагатай улирал бүр тооцоо нийлж баталгаажуулах;</p> <p>3.3. Хувь хүний орлогын албан татварын тайланг улирал бүрийн 10-ны өдрийн дотор тайлагнах, татварын байгууллагатай улирал бүр тооцоо нийлж баталгаажуулах;</p> <p>3.4. Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж холбогдох үнэн зөв мэдээллийг хугацаанд нь байршуулах;</p> <p>3.5. Санхүүгийн чиглэлээр шаардлагатай мэдээ, тооцоо судалгааг цаг хугацаанд нь үнэн зөв гаргах, удирдлагыг мэдээллээр хангах;</p> <p>3.6. Санхүүгийн аудитын шалгалтад хариуцсан ажлаа шалгуулах, зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган, биелүүлж ажиллах, давтан алдаа гаргахгүй байх;</p> <p>3.7. Цаг үеийн болон бусад асуудлаар удирдлагын өгсөн үүрэг даалгавар, шийдвэрийг хугацаанд нь хэрэгжүүлэх;</p> <p>3.8. Хариуцсан ажлаа цаг хугацаанд нь хариуцлагатай гүйцэтгэх, тулгамдсан асуудлыг тухай бүр танилцуулж, шийдвэрлүүлж байх;</p>	Байгууллагын үйл ажиллагааны үр дүн дээшилсэн байна.	Г Г Г Г Г Г Г
4 дүгээр зорилтын хүрээнд	<p>4.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандарт, дүрэм, технологийн горимыг чанд мөрдөх;</p> <p>4.2. Ажил олгогчийн зүгээс хууль тогтоомжийн хүрээнд нийцүүлэн тавьсан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг биелүүлж ажиллах;</p> <p>4.3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан байх, аюулгүй ажиллагааны зааварчилга авсан байх;</p>	Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, ажлын байрны хүрээнд явагдсан бусад үйл ажиллагаа бүрэн хангагдсан байна.	Г Г Г
Ажлын байрны зорилгын хүрээнд явуулах бусад үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> • Санхүүгийн холбогдолтой хууль дүрэмд орсон нэмэлт өөрчлөлт, шинээр гарсан дүрэм, журам зааврыг уншиж судлах, нийт ажилтнуудад мэдээлэх, танилцуулах ажлыг зохион байгуулах; • Нягтлан бодох бүртгэлийг бодлогын баримт бичиг болон байгууллагад мөрдөгдөж буй дүрэм, журмыг хэрэгжүүлэх; • Санхүүгийн прорамм хангамжийг бүрэн эзэмших, сайжруулах санал боловсруулж танилцуулах; • Хариуцсан ажлаа жилээр төлөвлөн, сар бүр удирдлагад тайлагнах, өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж ажиллах; • Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу тайлангийн жилд архивын нэгж болгосон баримтыг бичиг хэргийн ажилтанд бүртгэлээр хүлээлгэн өгөх; 		Г
III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА			
Боловсрол	Дээд боловсролтой, бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй		
Мэргэжил	Нягтлан бодох бүртгэл (041101), Санхүү (041201), Бизнесийн удирдлага (041301)		
Мэргэшил	Мэргэшсэн нягтлан бодогч		
Туршлага	Мэргэжлээрээ 5-аас доошгүй ажил ажилласан байх		
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	-Мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх; -Гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах; -Судалгааны ерөнхий арга зүйн мэдлэгтэй.	
	Асуудал шийдвэрлэх	-Өөрийн чиг үүргийн хүрээнд шийдлийн хувилбарыг боловсруулж, хариуцах; -Шаардлагатай асуудлаар судалгаа хийж, дүнг хариуцах.	
	Багаар	-Өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж	

ажиллах	хамтран ажиллах; -Бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох.
Бусад	- Албан хэрэг хөтлөх, баримт бичиг боловсруулах - Монгол хэл, бичгийн дүрмийн дагуу үг үсгийн болон утга найруулгын алдаагүй бичих - Компьютерийн өргөн хэрэглээний программуудыг ашиглаж чаддаг байх - Нягтлан бодох бүртгэлийн программ хангамж дээр ажиллах чадвартай байх

IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:
- Албаны дарга

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо: - Бичиг хэрэг, туслах ажилтан-1 - Технологийн жолооч-1	Бусад харилцах субъект - ИНЕГ - Зам, тээврийн яам - Сангийн яамны холбогдох албан тушаалтнууд - Ажил хэргийн хүрээнд харилцах бусад төрийн болон төрийн бус байгууллагууд, иргэд
---	--

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан: Албан тушаал: АХЛАХ ШИНЖЛЭН ШАЛГАГЧ 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр: Байгууллагын нэр: Шийдвэрийн огноо: Дугаар:
--	--

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр: АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБА

Шийдвэрийн огноо:
Дугаар:

АЛБАНЫ ДАРГА, ЕРӨНХИЙ ШИНЖЛЭН ШАЛГАГЧ

..... Ж.ЦОЛМОН
2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр



АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон.
- Байгууллагын зохион байгуулалтын бүтэц, орон тоонд өөрчлөлт орсон.

Холбогдох хууль тогтоомж, шийдвэрийн нэр, огноо: Зам, Тээврийн сайдын 2024 оны А/298 дугаар тушаал

Албан тушаалын тодорхойлолтын дугаар: АХОЗШША 25.01.02 (25-02)

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо: 2025 оны 01 дүгээр сарын 02 ны өдөр

Байгууллагын нэр:

Нэгжийн нэр:

Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба

Захиргаа судалгааны тасаг

Албан тушаалын нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Гадаад харилцаа хуулийн мэргэжилтэн

Ажлын цаг:

Ажлын байрны албан ёсны байршил:

Ердийн

ХУД -10 хороо Нисэхийн -1
АХОЗШША 105 тоот

Хөдөлмөрийн нөхцөл:

Онцгой нөхцөл:

Хэвийн

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах талаарх олон улсын гэрээ, хэлэлцээр болон хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх

Албан тушаалын зорилт:

1. Албаны олон талт хамтын ажиллагааг хариуцан зохион байгуулж гүйцэтгэх.
2. Осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны олон улсын иргэний нисэхийн байгууллагаас гаргасан стандарт зөвлөмжийн өөрчлөлт, шинэчлэлтийг үндэсний эрх зүйн баримт бичигт тусгах ажлыг зохион байгуулах хэрэгжилтэнд хяналт тавих.
3. Осол, зөрчлийн шинжлэн шалгах ажиллагааг гүйцэтгэхтэй холбоотой гадаад улсад мэдэгдэх болон бусад арга хэмжээнүүдийг зохион байгуулахад оролцох,
4. Албаны хуулиар олгогдсон бусад чиг үүргээ хэрэгжүүлэхэд биечилэн оролцох.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах – Т, хариуцан гүйцэтгэх – Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш

1 дүгээр зорилтын хүрээнд	1.1. Албаны гадаад харилцааны чиглэлээр явуулах үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах.	Энэ үйл ажиллагааг бүрэн дүүрэн гүйцэтгэсэн байх	Г
	1.2. Олон улсын болон бүс нутгийн хэмжээнд албаны үндсэн чиг үүргийн дагуу зохион байгуулагдах сургалт, семинар, уулзалт, зөвлөлгөөн түүнээс гарсан шийдвэрийн талаар мэдээлэх, сурталчлах ажлыг холбогдох ажилтнуудтай хамтран зохион байгуулаж гүйцэтгэх,	Энэ үйл ажиллагааг бүрэн дүүрэн гүйцэтгэсэн байх	Г
	1.3. Олон улсын болон бүс нутгийн хэмжээнд зохион байгуулагдах хурал, зөвлөлгөөн, сургалтанд шинжлэн шалгагч болон ажилтан, удирдах албан тушаалтнуудыг оролцуулахтай холбоотой ажлыг зохион байгуулах,	Зохион байгуулалтыг үр дүнтэй гүйцэтгэсэн байх	Г
2 дугаар зорилтын хүрээнд	2.1. Олон улсын иргэний нисэхийн байгууллагатай эрх зүйн зохицуулалтын өөрчлөлт шинэчлэлтэй холбоотой асуудлаар ИНЕГ-тай харицах ажлыг зохион байгуулах, гүйцэтгэх	Зохион байгуулалтын тогтолцоо бүрдүүлж хэвшил болгон ажиллах	Г
	2.2. Олон улсын иргэний нисэхийн байгууллагын Агаарын хөлгийн осол зөрчлийг шинжлэн шалгах тухай Хавсралт 13-т орсон нэмэлт, өөрчлөлт шинэчлэлтийн хэрэгжилтийн асуудлыг зохион байгуулах,	Цаг тухай бүрт нь авч хэрэгжүүлсэн байх	Г
3 дугаар зорилтын хүрээнд	3.1. Осол, зөрчлийн талаарх мэдээллийг холбогдох гадаад улсад илгээх, хариу мэдээг авах, мэдээллийн бүртгэл хөтлөх	Цаг тухай бүрт нь авч хэрэгжүүлсэн байх	Г
	3.2. Осол зөрчлийн талаарх холбогдох гадаад улсын байгууллагуудтай харьцах ажлыг зохион байгуулах	Цаг тухай бүрт нь авч хэрэгжүүлсэн байх	Г
	3.3. Осол зөрчилтэй холбоотой гадаад улсын байгууллагуудад тайлан, аюулгүй ажиллагааны зөвлөмжийг англи хэл дээр илгээх, хариу арга хэмжээг авах ажлыг зохион байгуулах	Цаг тухай бүрт нь авч хэрэгжүүлсэн байх	Г
4 дүгээр зорилтын хүрээнд	4.1. Байгууллагаас зохион байгуулж байгаа үйл ажиллагаанд оролцох Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль байгууллагын дотоод журам, ёс зүйн дүрмийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгох,	Дэг журам, ёс зүйн зөрчилгүй ажиллах	Г

III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА	
Боловсрол	Дээд боловсролын баклавын зэрэгтэй байх
Мэргэжил	Англи хэл, эрх зүйн зохих боловсролтой
Мэргэшил	Удирдлага зохион байгуулалтын
Туршлага	Төрийн болон хувийн байгууллагад 5 аас доошгүй жил ажилласан, ажлын зохих туршлагатай байх
Ур чадвар	Удирдан зохион байгуулах
	Дүн шинжилгээ хийх
	Асуудал шийдвэрлэх
	Манлайлах

Бусад	
-------	--

IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ	
Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:	
Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны дарга бөгөөд ерөнхий шинжлэн шалгагч	
Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:	Бусад харилцах субъект

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ	
Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:
Албан тушаал: АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ АХЛАХ ШИНЖЛЭН ШАЛГАГЧ  Х.НАРАНХҮҮ 2025 оны 07 дүгээр сарын 02 ны өдөр	Байгууллагын нэр: АХОЗШША Шийдвэрийн огноо: Дугаар:
Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:	
Байгууллагын нэр: АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБА	
Шийдвэрийн огноо:	
Дугаар: (тамга/тэмдэг)	
АЛБАНЫ ДАРГА БӨГӨӨД ЕРӨНХИЙ ШИНЖЛЭН ШАЛГАГЧ	
.....  2025 оны 07 дүгээр сарын 02-ны өдөр	Ж.ЦОЛМОН

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон.
- Байгууллагын зохион байгуулалтын бүтэц, орон тоонд өөрчлөлт орсон.

Холбогдох хууль тогтоомж, шийдвэрийн нэр, огноо:

Зам, Тээврийн сайдын 2024 оны А/298 дугаар тушаал

Албан тушаалын тодорхойлолтын дугаар:

АХОЗШША - 25-09

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

2025.01.02

Байгууллагын нэр:

Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба

Албан тушаалын нэр:

Бичиг хэрэг, туслах ажилтан

Ажлын цаг:

Ердийн

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Нэгжийн нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Ажлын байрны албан ёсны байршил:

ХУД -10 хороо Нисэхийн -1
АХОЗШША

Онцгой нөхцөл:

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны албан хэрэг хөтлөлтийг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам стандартын дагуу эрхлэн явуулж, гүйцэтгэлийн үр дүнг албаны даргын өмнө хариуцна.

Ажлын байрны үндсэн зорилт

- Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны албан хэрэг хөтлөлтийг холбогдох хууль тогтоомж, стандартын дагуу эрхлэн явуулах;
- Агаарын хөлгийн осол зөрчлийн үед шинжлэн шалгах багийн үйл ажиллагаанд оролцох, туслалцаа үзүүлэх;
- Лабораторын шинжилгээ судалгааны ажилагаанд туслалцаа үзүүлэх, нэгжийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд болон үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэхэд нэгжийн удирдлагад дэмжлэг үзүүлэх

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах-г Хариуцан гүйцэтгэх –Г Хянах-Х Шийдвэр-ш

1 дүгээр зорилтын хүрээнд	1.1.Байгууллагад ирсэн баримт бичгийн бүрдлийг /байгууллагын хаяг, албан тушаал нэр, он, сар өдрийг бүрэн зөв бичсэн эсэх/ шалган хүлээн авах;	Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа холбогдох стандарт, зааврын дагуу явагдсан байна.	Г
	1.2.Ирсэн баримт бичгийг албаны бичиг хэргийн системд болон бүртгэлийн дэвтэрт бүртгэх;	Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа холбогдох стандарт, зааврын дагуу явагдсан байна.	Г
	1.3. Ирсэн баримт бичгийн эх хувийг скайнердаж, удирдлагад танилцуулж удирдлагаас өгсөн цохолтын дагуу хариутай баримт бичигт бүртгэл хяналтын карт хөтөлж, бүтцийн нэгж ажилтанд цахим болон цаасан хэлбэрээр шилжүүлэх, ирсэн баримт бичгийн бүртгэлд гарын үсэг зуруулж хүлээлцэх		Г
	1.4.Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу хавтас файл үүсгэн хадгалах	Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа холбогдох хууль стандарт, зааврын дагуу явагдсан байна.	Г
	1.5.Явуулах баримт бичгийн төслийг ажилтнаас цахимаар хүлээн авч үг үсгийн алдааг хянаж хэвлэмэл хуудсанд буулгах		Г, Х
	1.6.Явуулсан баримт бичгийг бүртгэх ангилах, дугуйлах, хаяглах, илгээх;		Г
	1.7. Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын нэрийн жагсаалтын дагуу явуулсан баримт бичгийн үлдэх хувийг хавсралт баримт бичгийн хамт албан хэрэг бүрдүүлэх		Г
	1.8.Тушаалын төслийг цахимаар хүлээн авч, гарын үсэг зурагдсан эх хувьтай тулган, хэвлэмэл хуудсанд стандартын дагуу хэвлэж, баталгаажуулах;		Г
	1.9.Тушаалын бүртгэлийг хөтөлж холбогдох нэгжүүдэд цахимаар болон цаасаар хүргүүлэх ажлыг хариуцах;		Г
	1.10. Баримт бичгийн эргэлтийн мэдээг хагас, бүтэн жилээр гаргаж удирдлагад танилцуулах	Хариутай баримт бичгийн шийдвэрлэлтийн явцад хяналт тавьсан байна.	Г,Х
	1.11.Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу баримт бичгийг ангилан төрөлжүүлж хадгаламжийн нэгж бүрдүүлж, тогтоосон хугацаанд архивт шилжүүлэх;	Баримт бичгийг ангилан, төрөлжүүлж , хадгаламжийн нэгж үүсгэн, тогтоосон хугацаанд архивт хүлээлгэн өгсөн байна.	Г
	1.12.Стандартын дагуу хэвлүүлсэн хэвлэмэл бүртгэл хөтлөх, хэвлэмэл хуудасны зарцуулалтын мэдээг жилд 2 удаа гаргаж, удирдлагад танилцуулах;	Хэвлэмэл хуудсыг зөв хадгалж, бүртгэл судалгааг хөтөлж зарцуулсан байна.	Г
	1.13.Албан хэрэг хөтлөлтийн программын ашиглалтыг сайжруулах, цахим мэдээллийн сан үүсгэж хэвийн үйл ажиллагаанд хяналт тавих	Албан хэрэг хөтлөлтийн программыг сайжирч, цахим мэдээллийн сан үүссэн байна.	Г

2 дугаар зорилтын хүрээнд	2.1.Шинжлэн шалгагч нарын томилолт унааны асуудлыг зохион байгуулахад туслах	Үйл ажиллагаа хэвийн явагдсан байх	Г
	2.2.Шинжлэн шалгах ажиллагааны багаж хэрэгслүүдийг бэлтгэх авч явахад нь туслах		Г
	2.3.Багаж хэрэгсэл цэнэглэгч эд ангиудын зай хураагууруудыг тогтмол бэлэн байлгах		Г
	2.4.Шинжлэн шалгах ажиллагааны баримтуудыг бүрдүүлэхэд туслах		Г
	2.5.Осол, зөрчлийн газар дээрх хэмжилт, тооцооны ажиллагаанд туслах		
3 дугаар зорилтын хүрээнд	3.1.Шатах, тослох шингэний дээж авах, авч явах итгэмжлэгдсэн шинжилгээний газарт өгөх, хариуг авах;	Үйл ажиллагаа хэвийн явагдсан байх	Г
	3.2.Метал эд ангиудыг шинжилгээнд өгөх, хариу авах;		
	3.3.Бусад шинжилгээний ажлыг зохион байгуулахад туслах;		
	3.4.Лабораторийн техникийн аюулгүй ажиллагаа, гал болон хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн шаардлагыг биелүүлж ажиллах;		

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй	
Мэргэжил	Бичиг хэрэг, архивын ажилтан	
Мэргэшил	Архив, албан хэрэг хөтлөлтийн сургалтанд хамрагдсан байх	
Туршлага	Архив, албан хөтлөлтийн чиглэлээр ажиллаж байсан бол давуу тал болно.	
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	Мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх; Гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах; Судалгааны ерөнхий арга зүйн мэдлэгтэй.
	Асуудал шийдвэрлэх	Өөрийн чиг үүргийн хүрээнд шийдлийн хувилбарын боловсруулж, хариуцах; Шаардлагатай асуудлаар судалгаа хийж, дүнг хариуцах.
	Багаар ажиллах чадвар	Өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтарч ажиллах; Бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцаа бий болгох.
	Бусад	Албан хэрэг хөтлөх, баримт бичиг боловсруулах; Англи хэлний дунд түвшний мэдлэг; Компьютерийн өргөн хэрэглээний программ; Монгол бичгийг ашиглах, бичвэр боловсруулах чадамж;


IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

-

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо: 1.Албаны дарга 2.Ахлах шинжлэн шалгагч 3.Тасгийн дарга	Бусад харилцах субъект: - ИНЕГ-ын харьяа салбар , нэгжүүд; - Зам, тээврийн хөгжлийн яам - төрийн албаны зөвлөл - ажил хэргийн хүрээнд харилцах бусад төрийн болон төрийн бус байгууллага иргэд
--	--

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтын хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:
Албан тушаал: АХЛАХ ШИНЖЛЭН ШАЛГАГЧ /Х.НАРАНХҮҮ/ 2025 оны . . .01 дүгээр сарын 22 өдөр	Байгууллагын нэр: Шийдвэрийн огноо: Дугаар:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр: АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБА

Шийдвэрийн огноо:

Дугаар
(тамга/тэмдэг)

АЛБАНЫ ДАРГА, ЕРӨНХИЙ ШИНЖЛЭН ШАЛГАГЧ

.....


Ж.ЦОЛМОН

2025 оны 01 дүгээр сарын 22 ны өдөр

